



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БАТЛАГДСАН ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ 58.1 ХУВЬТАЙ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: НАГ-2026/04-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.

Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа

Утас: 260949 Цахим хаяг: battuyab@audit.gov.mn

Арга зүй, өгөгдлийн шинжилгээ хариуцсан

менежер Д.Баттулга

Утас: 329875, Цахим хаяг: battulgad@audit.gov.mn

Аудитын менежер П.Ундармаа

Утас: 261839, Цахим хаяг: undarmaap@audit.gov.mn

Ахлах аудитор Ш.Наранбаатар

Цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn

Аудитор:

Н.Хандмаа Цахим хаяг: khandmaan@audit.gov.mn

Н.Түмэнцэцэг Цахим хаяг: tumentsetsegn@audit.gov.mn

М.Минжин Цахим хаяг: minjinm@audit.gov.mn

М.Отгонбаяр Цахим хаяг: otgonbayarm@audit.gov.mn

Т.Шүрэнцэцэг Цахим хаяг: shurentsetsegt@audit.gov.mn

Э.Уянга Цахим хаяг: uyangae@audit.gov.mn

Т.Хандаймаа Цахим хаяг: khandaimitaat@audit.gov.mn

Б.Ариунзаяа Цахим хаяг: ariunzayabo@audit.gov.mn

Өгөгдлийн шинжилгээний аудитор:

М.Энхтөр Цахим хаяг: enkhturm@audit.gov.mn

Б.Эрдэнэхүү Цахим хаяг: erdenekhuub@audit.gov.mn



Улаанбаатар хот
2026 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яам болон Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т даалгасугай.

3.Аудитаар тогтоосон төлбөрийн актын мэдээллийг статистик мэдээний бүртгэлд бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т үүрэг болгосугай.

4.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2027 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (С.Бямбацогт), Эдийн засаг, хөгжлийн сайд (Ж.Энхбаяр), Сангийн сайд (Б.Жавхлан) нарт тус тус зөвлөсүгэй.


5.Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн актын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч (Б.Мөнхдөл)-д даалгасугай.

6.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн, Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Нийцлийн аудитын газар (Б.Баттуяа)-т үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2026 оны 03 дүгээр сарын 02-ны
өдрийн 03 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	1
Хүснэгтийн жагсаалт	2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	3
--	----------

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	3
--	---

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
-------------------------------	----------

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БАТЛАГДСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ШААРДЛАГАТАЙ САНХҮҮЖИЛТИЙН 53.7 ХУВИЙГ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУСГААГҮЙ БАЙНА.	5
--	----------

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 243 зорилтоос хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 128 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна.	5
---	---

Төсвийг батлахдаа Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх шаардлагыг бүрэн хангаагүй байна.	5
--	---

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг алдаатай төлөвлөсөн байна.	6
---	---

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна.	8
--	---

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 58.1 ХУВЬТАЙ БАЙНА.	10
---	-----------

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнд зарцуулах төсвийн 62.1 хувийг санхүүжүүлээгүй нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.	10
--	----

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг дөрвөн тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан байна.	12
--	----

Эдийн засгийн бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэхээр төлөвлөсөн ч 2025 онд 6.8 хувьд хүрсэн нь зорилтот түвшнийг хангаагүй байна.	13
--	----

Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт болох аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоогоогүй байна.	17
---	----

НҮБ-ын 2025 оны "Хүний хөгжлийн үзүүлэлт"-ээр Монгол улс 104-д эрэмбэлэгдсэн байна.	19
--	----

"Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого" тэргүүлэх чиглэлийн "авлигын индекс" 2025 онд 124 дүгээрт эрэмбэлэгдэж зорилтот үр дүнд хүрээгүй байна.	22
--	----

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэгчид "хугацаа болоогүй" гэж тайлагнасан байна.	25
---	----

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.	26
--	----


ДҮГНЭЛТ	27
----------------------	-----------

ЗӨВЛӨМЖ	28
----------------------	-----------

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	29
---	-----------

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР	32
--	-----------

Монгол Улсын Ерөнхий аудиторов
2026 оны 03 дүгээр сарын 12-ны
өдрийн 13 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон
төлбөрийн актын жагсаалт

Төлбөрийн акт						
№	Зөрчил хариуцах		Огноо	Хэрэгжүүл эх хугацаа	Мөнгөн дүн /мян.төгрөг/	Товч утга
	Байгууллага	Албан тушаалтан				
1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга В.Батчимэг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч, төсвийн багцын санхүүжилт, тайлагналт, бүртгэл хариуцсан шинжээч албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Билгүүнтөр	2026.03.12	2026.06.05	50,000.0	Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын дансанд төвлөрүүлэх

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	1
Хүснэгтийн жагсаалт	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	3

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ..... 4

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БАТЛАГДСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ШААРДЛАГАТАЙ САНХҮҮЖИЛТИЙН 53.7 ХУВИЙГ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУСГААГҮЙ БАЙНА..... 5

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 243 арга хэмжээнээс хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 128 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна.	5
Төсвийг батлахдаа Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх шаардлагыг бүрэн хангаагүй байна.	5
Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг алдаатай төлөвлөсөн байна.	6
Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна.....	8

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 58.1 ХУВЬТАЙ БАЙНА. 9

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнд зарцуулах төсвийн 62.1 хувийг санхүүжүүлээгүй нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.	9
Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг дөрвөн тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан байна.	11
Эдийн засгийн бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэхээр төлөвлөсөн ч 2025 онд 6.8 хувьд хүрсэн нь зорилтот түвшнийг хангаагүй байна.	12
Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт болох аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоогоогүй байна.	16
НҮБ-ын 2025 оны “Хүний хөгжлийн үзүүлэлт”-ээр Монгол улс 104-д эрэмбэлэгдсэн байна.	18
“Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлийн “авлигын индекс” 2025 онд 124 дүгээрт эрэмбэлэгдэж зорилтот үр дүнд хүрээгүй байна.	20
Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэгчид “хугацаа болоогүй” гэж тайлагнасан байна.....	23
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.....	24
ДҮГНЭЛТ	25
ЗӨВЛӨМЖ.....	26
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	27
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР.....	30

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
АХБ	Азийн хөгжлийн банк
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БСҮХ	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо
БХЯ	Батлан хамгаалах яам
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗГХХГ	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТЯ	Зам, тээврийн яам
МУЗГТХ	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТХХТТХ	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УХЖТ	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮТП	Үйлдвэрлэл, технологийн парк
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХБТТУТХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮ	Хяналт-шинжилгээ үнэлгээ
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ШСАА	Шадар сайдын ажлын алба
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө болон Хөгжлийн бодлогын дунд хугацааны баримт бичгүүд хоорондын уялдаа	5
Хүснэгт 2	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль хоорондын уялдаа, санхүүжилтийн дүн	5
Хүснэгт 3	Тэргүүлэх чиглэлд хамаарах төсөл, арга хэмжээний санхүүжилт	6
Хүснэгт 4	Төлөвлөлтийн алдааны нэгтгэл	6
Хүснэгт 5	ТАХ-ний дундаж үнэлгээ, хувиар	9
Хүснэгт 6	Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл	9
Хүснэгт 7	ТЕЗ-ийн санхүүжилтийн гүйцэтгэл	10
Хүснэгт 8	Тэргүүлэх чиглэлийн дундаж үнэлгээ /хувиар/	11
Хүснэгт 9	“Эдийн засгийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, Хөтөлбөр, ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл	12
Хүснэгт 10	“Эдийн засгийн бодлого” тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнд хамаарах ТАХ-ний шалгуур үзүүлэлтийн тоо, үнэлгээний дундаж /хувиар/	14
Хүснэгт 11	Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ болон хөтөлбөрийн үр дүн, ТАХ-ний тоо, үнэлгээ /хувиар/	16
Хүснэгт 12	“Хүний хөгжлийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, Хөтөлбөр, ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл	18
Хүснэгт 13	Төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээ	19
Хүснэгт 14	“Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, Хөтөлбөр, ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл	20
Хүснэгт 15	ТЕЗ-аас ХБ буюу хугацаа болоогүй үнэлэгдсэн ТАХ-г ЗГХХГ болон ҮАГ-аас үнэлсэн харьцуулалт	23
Хүснэгт 16	Аудитаар өгсөн зөвлөмжийн мэдээлэл	24
Хүснэгт 17	Зөвлөмжийн биелэлтийн дундаж үнэлгээ	24

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	“Эдийн засгийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ-ийн үр дүн	12
Дүрслэл 2	“Эдийн засгийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт	13
Дүрслэл 3	“Эдийн засгийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах төсөл, арга хэмжээний эх үүсвэрийн задаргаа	15
Дүрслэл 4	“Хүний хөгжлийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжээгүй шалтгаан	19
Дүрслэл 5	“Хүний хөгжлийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах төсөл, арга хэмжээний эх үүсвэрийн задаргаа	20
Дүрслэл 6	“Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ-ийн үр дүн	21
Дүрслэл 7	“Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах хөтөлбөрийн үр дүн	21
Дүрслэл 8	“Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүн	22
Дүрслэл 9	“Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлийн хүрээнд зарцуулсан хөрөнгийн мэдээлэл	23

Зураглалын жагсаалт

Зураглал 1	Хүний хөгжлийн индексийн 3 үзүүлэлт	18
------------	-------------------------------------	----

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1	Санхүүжих дүн тусгагдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	31
Хавсралт 2	Төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн үнэлгээний нэгтгэл	32-89
Хавсралт 3	Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээний нэгтгэл	90-93
Хавсралт 4	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээний нэгтгэл	94-95
Хавсралт 5	Тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээний нэгтгэл	96

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 оны аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрх, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1¹-д заасан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилго:

Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг Улсын Их Хуралд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөг хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, тухайн жилийн Төсвийн тухай хууль, хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа хангагдсан эсэх,
- Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлж, хэрэгжилтийг бодитой үнэлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх судалгааны арга зүйг ашиглав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төрийн аудитын тухай хууль,
- Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль,
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль,
- Өрийн удирдлагын тухай хууль,
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө”,
- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”,
- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол “Хяналт-шинжилгээ хийх журам”,
- Холбогдох бусад хууль, эрх зүйн актууд.

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Баттуяа хянан удирдаж, арга зүй, өгөгдлийн шинжилгээ хариуцсан менежер Д.Баттулга арга зүйгээр хангаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер П.Ундармаа нар хэрэгжүүлж, ахлах аудитор Ш.Наранбаатар, аудитор Э.Уянга, Н.Хандмаа, Н.Түмэнцэцэг, Т.Шүрэнцэцэг, М.Отгонбаяр, М.Минжин, Б.Ариунзаяа, Т.Хандаймаа, Өгөгдлийн шинжилгээний аудитор М.Энхтөр, Б.Эрдэнэхүү нар гүйцэтгэв.

¹ 9.8.1. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт Төрийн аудитын тухай хуульд заасан аудит хийж Улсын Их Хуралд танилцуулах;

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор “Монгол Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө”-г 6 шалгуур үзүүлэлт бүхий 4 тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн 29 үр дүнгийн 47 шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийн 63 үр дүнгийн 91 шалгуур үзүүлэлт, 328 төсөл, арга хэмжээний 373 шалгуур үзүүлэлтийн хүрээнд 19,359.1 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Тэргүүлэх чиглэл, ТЕЗ-ийн үр дүн, хөтөлбөрийн үр дүн, ТАХ-ний шалгуур үзүүлэлт, тоо

№	Тэргүүлэх чиглэлийн нэр	ТЕЗ-ийн үр дүн		Хөтөлбөрийн үр дүн		Төсөл, арга хэмжээ	
		арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	арга хэмжээ	шалгуур үзүүлэлт	арга хэмжээ	шалгуур үзүүлэлт
1	Эдийн засгийн бодлого	12	16	30	43	167	189
2	Бүсчилсэн хөгжлийн бодлого	3	3	6	6	53	58
3	Хүний хөгжлийн бодлого	8	22	15	18	58	72
4	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	6	6	12	24	50	54
Нийт дүн		29	47	63	91	328	373

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ нь “Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл, бусад” эх үүсвэрээс санхүүжихээр байна. Санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөгөөнд тусгасан байдлыг ангилж харуулбал:

ТАХ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, санхүүжих дүн

Эх үүсвэр	Улсын болон ОНТ	Гадаад зээл, тусламж	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ	Бусад эх үүсвэр	/тэрбум төгрөг/	
						Эх үүсвэргүй ²	Нийт дүн
ТАХ	188	83	19	32	4	2	328
Шалгуур үзүүлэлт	221	91	23	32	4	2	373
Санхүүжих дүн	5,276.7	4,151.5	4,167.1	4,463.6	1,300.2	-	19,359.1

Тайлбар: ОНТ-орон нутгийн төсөв

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т “Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хүргүүлнэ. Улсын Их Хурал 06 дугаар сарын 01-ний дотор батална” гэж заасан.

Засгийн газраас 2024 оны 04 дүгээр сарын 30-нд төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн боловч, УИХ-аас хуулийн хугацаанд батлаагүй, 09 дүгээр сарын 27-ны өдөр УИХ-д дахин өргөн мэдүүлж, 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-д заасан аргачлалын дагуу тэргүүлэх чиглэл, хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг үнэллээ.

Бодлогын баримт бичгийн үр дүнг “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.4-т зааснаар хэрэгжилт нь зорилтот түвшний 85 хувиас дээш бол “Үр дүн гарсан”, 85 хувьд хүрээгүй бол “Үр дүнгүй” гэж дүгнэсэн болно.

² Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнд санхүүжилтийн эх үүсвэр тусгаагүй.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БАТЛАГДСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ШААРДЛАГАТАЙ САНХҮҮЖИЛТИЙН 53.7 ХУВИЙГ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУСГААГҮЙ БАЙНА.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 243 арга хэмжээнээс хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 128 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна.

1.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13³, 6 дугаар зүйлийн 6.10.1⁴, 9 дүгээр зүйлийн 9.2.6⁵-д тус тус зааснаар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээнүүдтэй нийцүүлэн боловсруулахаар заасан байна.

1.2 Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг Хөгжлийн бодлогын дунд хугацааны баримт бичгүүдэд нийцсэн эсэхийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1. МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө болон Хөгжлийн бодлогын дунд хугацааны баримт бичгүүд хоорондын уялдаа

№	Хөгжлийн бодлогын дунд хугацааны баримт бичиг	Арга хэмжээ, зорилтын тоо	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд нийцсэн ТАХ-ний тоо
1	Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	243	128
2	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	580	169

Эх сурвалж. МУХТЖҮЧ, МУЗГҮАХ, МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө

1.3 Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 243 арга хэмжээнээс 128 буюу 52.7 хувь нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байна.

1.4 Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 614 зорилт байх ба 2025-2028 онд хэрэгжих 580 зорилтоос 169 зорилт буюу 29.1 хувь нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээтэй нийцсэн байна.

Төсвийг батлахдаа Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх шаардлагыг бүрэн хангаагүй байна.

1.5 Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан 328 төсөл, арга хэмжээний 373 шалгуур үзүүлэлтээс 178 төсөл, арга хэмжээний 207 шалгуур үзүүлэлт нь Улсын төсвөөс санхүүжихээр батлагдсан байна. Үүнээс 18 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг тусгаагүй байна. /Жагсаалтыг хавсралт 1-ээс харна уу./

1.6 Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуультай уялдсан байдлыг авч үзвэл:

Хүснэгт 2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль хоорондын уялдаа, санхүүжилтийн дүн

/тэрбум төгрөгөөр/

Улсын төсвөөр хэрэгжүүлэх			Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд							
			Туссан				Тусгаагүй			
TAX	Шалгуур үзүүлэлт	Мөнгөн дүн	TAX	Шалгуур үзүүлэлт	Мөнгөн дүн	Хувь	TAX	Шалгуур үзүүлэлт	Мөнгөн дүн	Хувь
160	182	4,630.9	74	85	1,499.1	46.3	86	97	2,733.4	53.7

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

³ 4.1.13.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг;

⁴ 6.10.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх;

⁵ 9.2.6.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жил бүрийн төсвийг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн батлах;

1.7 Улсын төсвөөс санхүүжих нийт 160 төсөл, арга хэмжээнээс 74 төсөл, арга хэмжээ буюу 46.3 хувь нь Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд тусгагдан, 86 төсөл, арга хэмжээ буюу 53.7 хувь нь батлагдаагүй байна.

1.8 Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний задаргааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. Тэргүүлэх чиглэлд хамаарах төсөл, арга хэмжээний санхүүжилт /тэрбум төгрөгөөр/

№	Тэргүүлэх чиглэлийн нэр	Монгол Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөө			Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль		
		ТАХ	Шалгуур үзүүлэлт	Санхүүжих дүн	ТАХ	Шалгуур үзүүлэлт	Санхүүжих дүн
1	Эдийн засгийн бодлого	73	80	2,073.40	37	38	684.3
2	Бүсчилсэн хөгжлийн бодлого	16	17	598.4	8	8	159.4
3	Хүний хөгжлийн бодлого	39	51	1,682.90	16	24	532.7
4	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	32	34	276.2	13	15	122.7
	Нийт	160	182	4,630.90	74	85	1,499.10

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

1.9 Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд “Улсын төсөв”-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд бүрэн тусгагдаагүй нь Улсын төсвийг ХБТТУТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.10.3⁶, Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8⁷-д заасан шаардлагуудтай нийцүүлэн боловсруулаагүй байна.

1.10 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 70 орчим хувийг төсвийн тухай хуульд тусгаагүй нь төлөвлөгөөний хэрэгжилтэд нөлөөлж, зорилтот түвшинд хүрэхгүй байх үр дагаврыг үүсгэж байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг алдаатай төлөвлөсөн байна.

1.11 Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22-т “шалгуур үзүүлэлт” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг”, 9 дүгээр зүйлийн 9.4.1-д “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах;” гэж заасан байна.

1.12 Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт оновчгүй, хэмжих нэгж уялдаагүй, суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус, суурь түвшин алдаатай, зорилтот түвшин хэт өндөр, хариуцагч байгууллагыг буруу тодорхойлсон байна.

Хүснэгт 4. Төлөвлөлтийн алдааны нэгтгэл

№	ТЕЗ-ийн нэр	ШҮ оновч-гүй	Хэмжих нэгж уялдаагүй	СТ, ЗТ хэмжигдэхүйц бус	СТ алдаатай баталсан	ЗТ хэт өндөр	ХБ-г буруу тодорхойлсон	Давхардуулан баталсан	Нийт тоо
1	АҮЭБЯ	1	1						2
2	БОУАӨЯ			5					5
3	Боловсролын яам	1	1	2	7	1	2		14
4	ГБХНХЯ		2	1					3
5	ЗТЯ			3	8				11
6	НЗДТГ	1	1	1				3	6
7	Сангийн яам				2				2
8	ССАЖЗЯ				1				1
9	ХББОСЯ			2			1		3
10	ХЭҮК						1		1
11	ШСАА					1			1

⁶ 6.10.3.улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

⁷ 27.1.8.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх;

12	ЭЗХЯ					2	5		7
13	ЭМЯ			4	1				5
14	ЭХЯ	3							3
Нийт		6	5	18	19	4	9	3	64

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл. /Тайлбар: ШҮ-шалгуур үзүүлэлт, СТ-суурь түвшин, ЗТ- зорилтот түвшин, ХБ-хариуцагч байгууллага /

1.13 Дээрх хүснэгтээс харахад 8 Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон 11 хөтөлбөрийн үр дүн, 45 төсөл, арга хэмжээнд төлөвлөлтийн алдаа гарсан байна. Тухайлбал;

Шалгуур үзүүлэлт оновчгүй:

- 1.7.3.3 “Багануурын цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх” арга хэмжээний “... төслийг хэрэгжүүлэх” гэдгээр ТАХ-г тусгасан ч “барилгын ажлын гүйцэтгэл”-гээ шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон нь уялдаагүй,
- 2.1.2.1 “Тавантолгой үйлдвэрлэл, технологийн парк түшиглэсэн Кокс-химийн цогцолбор үйлдвэрийн бэлэн байдлыг хангах” арга хэмжээний “...үйлдвэрийн бэлэн байдлыг хангах” гэдгээр ТАХ-г тусгасан ч “барилгын ажлын гүйцэтгэл” гэж шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон нь уялдаагүй байна.

Хэмжих нэгж уялдаагүй:

- 2.2.2.4 “Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг “Хүлээлтийн хугацааны бууралт” гэж тодорхойлсон ч суурь болон зорилтот түвшнийг “хувиар” илэрхийлсэн нь хэмжих нэгж, шалгуур үзүүлэлтийг уялдаагүй тусгасан,
- 3.5.1.4 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх” арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг “мянган хүн” гэж тодорхойлсон ч хүрэх түвшнийг “хувиар” илэрхийлсэн байгаа нь үнэлэхэд хүндрэл учруулж байна.

Суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус:

- 1.6.1.6 “Өмнөговь аймгийн Гурвантэс суманд “Шивээхүрэн нурмаг ачааны терминал” барих” арга хэмжээний суурь болон зорилтот түвшнийг “0” байхаар төлөвлөсөн, /ЗТЯ/
- 4.6.1.9 “Аймаг, нийслэлийн хэмжээнд 2002 оноос өмнөх нийт барилга байгууламжийг паспортжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх” арга хэмжээний зорилтот түвшнийг суурь түвшнээс бууруулсан, /ХББОСЯ/
- 3.1.4 “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийг боловсронгуй болгоно” арга хэмжээний суурь болон зорилтот түвшнийг ижил үзүүлэлтээр тусгасан. /Хөтөлбөрийн үр дүн, ЭМЯ/

Суурь түвшин алдаатай:

- 3.1.2.1 “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад алсын зайн анагаах ухаан (телемедицин)-ыг хөгжүүлэх” арга хэмжээний алсын зайн анагаах ухааны МНКАРДИО программд бүртгэлтэй байгууллагын тоо 2023 оны байдлаар 458 байхад 250 гэж суурь түвшнийг алдаатай төлөвлөсөн,
- 1.5.1 “Төмөр замын ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.” хөтөлбөрийн суурь түвшин 2023 онд төмөр замаар тээсэн экспортын ачааны хэмжээ 11.1 сая байхад суурь түвшнийг 32.4 гэж үндэслэлгүй тодорхойлсон, /Хөтөлбөрийн үр дүн, ЗТЯ/
- 3.2 “Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна” ТЕЗ-ийн үр дүнгийн суурь түвшнийг 2024 онд улсын хэмжээнд 52.7 хувьтай байхад 58.8 хувь гэж тусгасан. /Боловсролын яам/

Зорилтот түвшин хэт өндөр:

- 2.1.2.4 “Чөлөөт бүсүүдийн инженерийн дэд бүтцийг байгуулах” арга хэмжээг Замын-Үүд чөлөөт бүсийн дэд бүтцийг байгуулах ажлын хүрээнд Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг хооронд нь холбох 8 эгнээтэй 40 метр авто зам, бүс доторх авто зам, Замын-Үүд сумаар дамжин өнгөрөх олон улсын АН-03 авто замтай холбох 1.2 км авто зам, ногоон байгууламжуудыг нэг жилд хийхээр тусгаж, зорилтот түвшнийг 100 хувь байхаар тодорхойлсон нь шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй,
- 1.1.1.1 “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, Чөлөөт худалдааны хэлэлцээр, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрүүдийг байгуулах” төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт “Тайландын Хаант Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улстай Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулах арга хэмжээний хэрэгжилт”-ийг МУЗГ-ын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг

2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д тусгаагүй, зорилтот түвшнийг 100 хувь байхаар төлөвлөн шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй.

Хариуцагч байгууллагыг буруу тодорхойлсон:

- 3.2.1.10 “Халаалтын урсгал зардал өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэх, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй технологид шилжүүлэх, бэлтгэл хангах” төсөл, арга хэмжээг нэг маягийн барилгын зураг төсвийг ХББОСЯ-ны харьяа “Барилгын хөгжлийн төв” гүйцэтгэх байхад Боловсролын яам гэж тодорхойлсон,
- 1.1.3 “Хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг хөгжүүлнэ” хөтөлбөрийн үр дүнг 2024.07.10-ны өдрийн өөрчлөлт орсон МУЗГТ хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3-т Монгол Улсын Шадар сайдын эрхлэх ажилд хамаарах байхад хариуцагч байгууллагыг ЭЗХЯ гэж баталсан,
- 4.2 “Шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ” ТЭЗ-ийн үр дүнг Хүний эрхийн үндэсний комиссын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй байхад хариуцагч байгууллагаар баталсан.

Төсөл, арга хэмжээг давхардуулан төлөвлөсөн:

- 2.3.1.22 “Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төслийг хэрэгжүүлэх” төсөл, арга хэмжээг 2.3.1.21 дүгээр төсөл, арга хэмжээтэй, /НЗДТГ/
- 2.3.1.18 “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл”-ийн 2, 3 дугаар үе шатыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2 шалгуур үзүүлэлтийг 2.3.1.20 дүгээр төсөл, арга хэмжээтэй тус тус давхардуулан баталсан байна.

1.14 Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10-т “шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх”, 5.1.11-т “төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх” зэрэг зарчмуудыг хангаагүй байгаа нь Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бодитой үнэлэх боломжийг хязгаарласан байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна.

1.15 Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл шаардлагатай 102 төсөл, арга хэмжээнээс 22 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ батлагдаагүй байгаа нь ХБТТУТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.10.2-т “санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан... байх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Тухайлбал;

- 1.12.4.3 “Салбар дундын, салбар дамнасан судалгаа хөгжүүлэлтэд түшиглэсэн хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засаг, засаглалын цогц нэгдэл бүхий шинжлэх ухаан, технологийн паркийн төслийг хэрэгжүүлэх”, шалгуур үзүүлэлт – ажлын гүйцэтгэл, /ЭЗХЯ/
- 4.6.1.2 “Онцгой байдлын ерөнхий газрын мэргэжлийн сургалтын төвийн барилга барих”, шалгуур үзүүлэлт – шинээр байгуулах анги, салбар, нэгж, /ОБЕГ/
- 2.3.2.2 “Засгийн газрын “Нэг цэг”-ийн үйлчилгээний цогцолборын зураг төсөв, барилга угсралтын ажлыг эхлүүлэх”, шалгуур үзүүлэлт- дэд бүтцийн бүтээн байгуулалт /ЗГХЭГ/ гэх мэт.

1.16 Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвгүй арга хэмжээ тусгаж байгаа нь Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрэхгүй байх, гүйцэтгэл хангалтгүй үнэлэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ 58.1 ХУВЬТАЙ БАЙНА.

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээнд зарцуулах төсвийн 62.1 хувийг санхүүжүүлээгүй нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.

2.1. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээг өмнөх онтой харьцуулахад, тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн дундаж үнэлгээ 74.3-аас 20.9 хувь болж буурсан, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн дундаж үнэлгээ 56.9-өөс 63.7 хувь, хөтөлбөрийн үр дүнгийн дундаж үнэлгээ 56.6-аас 62.0 хувь, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 52.1-ээс 58.1 хувь болж тус тус нэмэгдсэн байна.

2.2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан 373 шалгуур үзүүлэлт бүхий 328 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээг Төсвийн ерөнхийлөн захирагчдаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 5. ТАХ-ний дундаж үнэлгээ, хувиар

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Тоо		Дундаж үнэлгээ	
		TAX	Шалгуур үзүүлэлт	ТЕЗ	ҮАГ
1	Авлигатай тэмцэх газар	2	2	100.0	75.5
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	20	24	64.9	44.4
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	16	22	80.4	51.6
4	Батлан хамгаалах яам	4	4	90.0	90.0
5	Боловсролын яам	17	27	87.8	77.2
6	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо	5	5	-	38.1
7	Гадаад харилцааны яам	3	3	100.0	83.3
8	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	2	2	70.0	20.0
9	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	11	12	92.7	67.3
10	Зам, тээврийн яам	53	54	60.5	48.9
11	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	2	2	70.0	-
12	Монголбанк	2	2	100.0	50.0
13	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	21	25	89.2	62.4
14	Онцгой байдлын ерөнхий газар	3	3	94.0	70.0
15	Сангийн яам	6	6	94.0	72.1
16	Санхүүгийн зохицуулах хороо	4	4	85.0	82.5
17	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	12	13	65.8	40.6
18	Стандарт хэмжил зүйн газар	3	3	93.3	88.7
19	Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	1	1	100.0	100.0
20	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	25	25	90.9	70.2
21	Хууль зүй, дотоод хэргийн яам	10	12	85.0	75.6
22	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	17	22	75.6	61.2
23	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	11	11	51.8	45.7
24	Шадар сайдын ажлын алба	5	6	100.0	56.7
25	Шүүхийн Ерөнхий зөвлөл	1	1	-	-
26	Эдийн засаг, хөгжлийн яам	18	22	85.3	59.2
27	Эрүүл мэндийн яам	21	24	86.9	68.6
28	Эрчим хүчний яам	34	36	60.6	47.1
Нийт		328	373	-	-

Эх сурвалж: <https://new.unelgee.gov.mn>, Аудитын судалгааны нэгтгэл

2.3. Гүйцэтгэл хангалтгүй байгаа нь хариуцагч байгууллагын зохион байгуулалт, гэрээ хэлэлцээр, худалдан авах ажиллагаа удааширсан, төлөвлөлтийн алдаа, санхүүжилт зэргээс шалтгаалсан байна.

2.4. Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт 7,336.4 тэрбум төгрөг зарцуулсан нь батлагдсан төсвийн 37.9 хувийг эзэлж байна.

Хүснэгт 6. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
		TAX тоо	Мөнгөн дүн	TAX тоо	Мөнгөн дүн
1	Улсын болон орон нутгийн төсөв	188	5,276.7	118	1,449.3
2	Гадаадын зээл, тусламж	83	4,151.5	43	1,429.6
3	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	19	4,167.1	11	2,852.0
4	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ	32	4,463.6	-	-
5	Бусад эх үүсвэр	4	1,300.2	6	1,605.5
6	Эх үүсвэргүй	2	-	-	-
Нийт дүн		328	19,359.1	178	7,336.4

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.5. Нийт гүйцэтгэлийн 38.9 хувь буюу 2,852.0 тэрбум төгрөгийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, 21.9 хувь буюу 1,605.5 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэр, 19.8 хувь буюу 1,449.3 тэрбум төгрөгийг улсын болон орон нутгийн төсөв, 19.5 хувь буюу 1,429.6 тэрбум төгрөгийг гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

2.6. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 328 төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хариуцагч байгууллагаар харуулбал:

Хүснэгт 7. ТЕЗ-ийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл (тэрбум төгрөг)

№	Хариуцагч байгууллагын нэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
		шалгуур үзүүлэлтийн тоо	Санхүүжих дүн	шалгуур үзүүлэлтийн тоо	Санхүүжсэн дүн
1	Авлигатай тэмцэх газар	2	-	1	0.6
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	24	5,714.4	13	476.6
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	22	290.5	7	42.4
4	Батлан хамгаалах яам	4	49.7	-	-
5	Боловсролын яам	27	657.7	19	339.1
6	Боомтын сэргэлтийн Үндэсний хороо	5	87.7	-	-
7	Гадаад харилцааны яам	3	9.6	3	7.8
8	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар	2	3.0	-	-
9	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	12	778.8	10	351.7
10	Зам, тээврийн яам	54	4,195.3	28	398.0
11	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	2	210.1	-	-
12	Монголбанк	2	1,200.0	1	1,260.8
13	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	25	2,274.3	15	488.4
14	Онцгой байдлын ерөнхий газар	3	56.9	3	36.3
15	Сангийн яам	6	245.0	4	259.2
16	Санхүүгийн зохицуулах хороо	4	0.2	-	-
17	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	13	124.4	6	56.0
18	Стандарт, хэмжил зүйн газар	3	3.1	2	2.9
19	Төрийн албаны зөвлөл	1	1.5	-	-
20	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	25	612.5	13	275.0
21	Хууль зүй, дотоод хэргийн яам	12	110.3	11	80.5
22	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	22	148.5	14	95.6
23	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	11	286.2	5	51.0
24	Шадар сайдын ажлын алба	5	124.0	-	-
25	Шүүхийн Ерөнхий зөвлөл	1	0.1	-	-
26	Эдийн засаг, хөгжлийн яам	23	120.2	1	1.9
27	Эрүүл мэндийн яам	24	411.0	12	192.6
28	Эрчим хүчний яам	36	1,644.1	16	2,919.6

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.7. Хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилт хангалтгүй байгаа нь төсвийн эх үүсвэртэй төсөл, арга хэмжээ Улсын төсөвт бүрэн тусгагдаагүй, 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр санхүүжилт хасагдаж, зарим хариуцагч татан буугдсан, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч тодорхойгүй зэрэг шалтгаантай байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг урьдчилсан тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөхгүй байна.

2.8. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т “урьдчилсан үнэлгээ хийсэн, түншлэлээр хэрэгжүүлэх төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах” гэж заасны дагуу 32 төсөл, арга хэмжээг 4,463.6 тэрбум төгрөгөөр баталсан байна.

2.9. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх 3,670.7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 21 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй, 429.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 10.0-50.0 хувьтай, 354.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээ 85.0 хувиас дээш буюу үр дүн гарсан байна.

2.10. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээний санхүүжилт хийгдээгүйгээс “Үр дүнгүй” үнэлэгдсэн байна. Тухайлбал;

- 1.4.3.7 “Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах” санхүүжих дүн 238.0 тэрбум төгрөг, /АҮЭБЯ/
- 1.4.3.14 “Тавантолгой” үйлдвэрлэл, технологийн парк түшиглэсэн Кокс-химийн цогцолбор үйлдвэрийн бэлэн байдлыг хангах” санхүүжих дүн 742.7 тэрбум төгрөг, /АҮЭБЯ/
- 1.5.1.3 “Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн-Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн 300 км төмөр зам барих” санхүүжих дүн 683.7 тэрбум төгрөг, /ЗТЯ/
- 1.5.1.4 “Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр замын төслийн хүрээнд Бичигт-Зүүнхатавч боомтын хил холболтын төмөр зам барих” санхүүжих дүн 556.7 тэрбум төгрөг, /ЗТЯ/
- 1.5.2.2 “Налайх-Замын-Үүд чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх” санхүүжих дүн 336.0 тэрбум төгрөг, /ЗТЯ/
- 1.5.2.8 “Бургастай хилийн боомтыг 320 км хатуу хучилттай авто замаар холбох төслийг хэрэгжүүлэх” санхүүжих дүн 215.1 тэрбум төгрөг, /ЗТЯ/
- 1.7.3.3 “Багануурын цахилгаан станц барих” санхүүжих дүн 186.0 тэрбум төгрөг, /ЭХЯ/
- 1.7.3.16 “Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 10 МВт-ын нар, 5 МВт буюу 20 МВт-ц-ийн батарейн станц барих төслийг хэрэгжүүлэх” санхүүжих дүн 99.8 тэрбум төгрөг /ЭХЯ/ гэх мэт.

2.11. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2⁸-т заасны дагуу Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд түншлэлээр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээнд урьдчилсан судалгаа хийгээгүй, төлөвлөлтийн алдаатай, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй арга хэмжээнүүд төлөвлөсөн байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг дөрвөн тэргүүлэх чиглэлийн хүрээнд баталсан байна.

2.12. Тэргүүлэх чиглэлийн 4 бодлогыг үнэлэх 6 шалгуур үзүүлэлт батлагдсанаас 2 шалгуур үзүүлэлт нь Монгол Улсын 2025 оны үндэсний хэмжээний зарим статистик тоон мэдээлэл үзүүлэлт болон олон улсын байгууллагаас гаргадаг холбогдох тайлан гарах хугацаа болоогүйгээс шалтгаалж үнэлэх боломжгүй байна. Үүнд:

Хүснэгт 8. Тэргүүлэх чиглэлийн дундаж үнэлгээ /хувиар/

№	Тэргүүлэх чиглэлийн нэр	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Дундаж үнэлгээ		
						ТЕЗ	ЗГХХГ	ҮАГ
1	Эдийн засгийн бодлого	Эдийн засгийн өсөлт	Хувь	6	8	0	-	40.0
2	Бүсчилсэн хөгжлийн бодлого	Аймгуудын өрсөлдөх чадварын индексийн дундаж	Хувь	66.5	70	0	-	Үнэлэх боломжгүй
		Хотын хөгжлийн индекс	Оноо	0.464	0.57	70	45	43.4
3	Хүний хөгжлийн бодлого	Хүний хөгжлийн индекс	Эрэмбэ	96	95	10	0	0.0
4	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж	Эрэмбэ	113/215	112/215	100	100	Үнэлэх боломжгүй
		Авлигын индекс	Эрэмбэ	121/180	118/180	0	100	0.0

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.13. Тэргүүлэх чиглэлийн үр дүнгээс “үнэлэх боломжгүй” гэсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- “Бүсчилсэн хөгжлийн бодлого” үр дүнгийн “аймгуудын өрсөлдөх чадварын индексийн дундаж” шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй шалтгаан нь “эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв” 2024, 2025 онд аймгуудын өрсөлдөх чадварын тайланг гаргаагүй байна,
- “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” үр дүнгийн “дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж” шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй шалтгаан нь 2025 оны статистик тайлан гарах хугацаа болоогүйгээс шалтгаалсан байна.

⁸ 8.1.2 урьдчилсан үнэлгээ хийсэн, түншлэлээр хэрэгжүүлэх төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах

ТЭРГҮҮЛЭХ
ЧИГЛЭЛ - I

Эдийн засгийн бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэхээр төлөвлөсөн ч 2025 онд 6.8 хувьд хүрсэн нь зорилтот түвшнийг хангаагүй байна.

2.14. Эдийн засгийн бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд нийт 209 үр дүнгийн 248 шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 83 нь үр дүн гарч, 160 нь үр дүнгүй, 5 шалгуур үзүүлэлт үнэлэх боломжгүй байна.


Хүснэгт 9. “Эдийн засгийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, Хөтөлбөр, ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл

Үзүүлэлт	Нийт үр дүн /тоо/	Нийт шалгуур үзүүлэлт /тоо/	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ			
			Үр дүн гарсан /тоо/	Үр дүнгүй /тоо/	ҮБ /тоо/	Дундаж үнэлгээ /хувь/
ТЕЗ-ийн үр дүн	12	16	4	11	1	39.5
Хөтөлбөрийн үр дүн	30	43	13	27	3	56.5
ТАХ-ний үр дүн	167	189	66	123	1	53.8
Нийт дүн	209	248	83	160	5	-

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл /Тайлбар: ҮБ-үнэлэх боломжгүй/

2.15. Эдийн засгийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнг тооцох бизнесийн орчны судалгааны ерөнхий үзүүлэлтийн үнэлгээг 3 жил тутам хийгддэг бөгөөд хамгийн сүүлд 2023 онд хийгдсэн ба дараагийн тайлан 2026 онд хийгдэх тул үнэлэх боломжгүй байна.

Дүрслэл 1. “Эдийн засгийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ-ийн үр дүн



Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.16. Төлөвлөлтөөс шалтгаалж үр дүнгүй үнэлэгдсэн дараах ТЕЗ-ийн үр дүнд хамаарах шалгуур үзүүлэлт байна. Тухайлбал;

Зорилтот түвшнийг бодитой тодорхойлоогүй:

- 1.7 “Цахилгаан эрчим хүчний дотоодоос хангах хувь” суурь түвшин-77.7 хувь, зорилтот түвшин-83.0 хувь, 2025 онд цахилгаан эрчим хүчний хэрэглээ боловсруулалт 12,612.5 сая кВт.ц, үүнээс дотоодын эх үүсвэрээс 9,911.8 сая кВт.ц-ийг түгээлт хийж цахилгаан эрчим хүчний 78.6 хувийг дотоодоос хангаж зорилтот түвшинд хүрээгүй байна. /ЭХЯ/

Шалгуур үзүүлэлтийг оновчгүй тодорхойлсон:

- 1.2 “Хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт” статистик мэдээ 2026 оны 2 дугаар улиралд гардаг ба урьдчилсан дүнгээр зорилтот үр дүнг хангаагүй, /ХХААХҮЯ/
- 1.3 “Сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын хангамж” /статистик мэдээ 2026 оны 2 дугаар улиралд гардаг ба урьдчилсан дүнгээр зорилтот үр дүнг хангаагүй, /ХХААХҮЯ/ зэрэг ТЕЗ-ийн үр дүнд хамаарах шалгуур үзүүлэлтүүд байна.

2.17. Эдийн засгийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах 30 хөтөлбөрийн үр дүнгийн 43 шалгуур үзүүлэлтээс зорилтот үр дүнг хангаагүй 27, үр дүн гарсан 13, үнэлэх боломжгүй 3 шалгуур үзүүлэлт байна.


2.18. Үнэлэх боломжгүй 3 шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшнийг тодорхойлох статистик мэдээний хугацаа болоогүй, статистик мэдээг гаргахаа больсон, статистик мэдээг тооцдоггүй зэргээс шалтгаалсан байна. Тухайлбал;

- 1.1.2 “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулна” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болох Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж /ROA/, хувийн

- хэвшлийн нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь нь дараа оны 03 сарын 15-аас хойш жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд үндэслэн тооцдог,
- 1.8.1 “Жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт болох Шинээр нэмэгдэх аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг тооцдог аргачлал байхгүй, үзүүлэлт тус бүрээр огт тооцдоггүй байна,
 - 1.10.2 “Ногоон эдийн засгийн санхүүжилтийн механизмыг бүрдүүлнэ” хөтөлбөрийн “Үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн нэгжид ногдох нүүрсхүчлийн хийн ялгаруулалт, 2015 оны зэрэгцүүлэх үнээр” гэсэн шалгуур үзүүлэлтийн Нүүрсхүчлийн хийн ялгаруулалтын статистик мэдээ 2020 оноос хойш гараагүй тул тус тус үнэлэх боломжгүй байна.

2.19. Харин “үр дүнгүй” үнэлэгдсэн 22 хөтөлбөрийн үр дүнгийн 27 шалгуур үзүүлэлт нь төлөвлөлтийн алдаатай, санхүүжилт бүрэн шийдэгдээгүй, хариуцагч байгууллагын зохион байгуулалт зэргээс шалтгаалж зорилтот үр дүнд хүрээгүй байна.

Дүрслэл 2. “Эдийн засгийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт



Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.20. Төлөвлөлтийн алдаа, хариуцагч байгууллагын зохион байгуулалт болон санхүүжилтээс шалтгаалж дараах хөтөлбөрийн үр дүнд хамаарах шалгуур үзүүлэлт “0 хувь”-аар үр дүнгүй үнэлэгдсэн байна. Тухайлбал;

Хариуцагч байгууллагын зохион байгуулалтаас шалтгаалсан:

- 1.1.1 “Уул уурхайн бус гадаад худалдаа /экспорт” / зорилтот түвшин-1,870.0 мянган ам.доллар, хүрсэн түвшин-1,024.4 мянган ам.доллар буюу суурь түвшнээс буурсан үзүүлэлттэй, /ГЕГ/
- 1.7.2 “Сэргээгдэх эрчим хүчний нийт суурилагдсан хүчин чадалд эзлэх хувь” /зорилтот түвшин – 20 хувь, хүрсэн түвшин – 17.5 хувь буюу Бөөрөлжүүтийн 150 Мвт, Тосонцэнгэлийн 22Мвт-н хүчин чадалтай станц ашиглалтад орж суурилагдсан хүчин чадал нэмэгдсэнтэй холбоотойгоор сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 17.5 болж буурсан, /ЭХЯ/
- 1.9.1 “Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа” /суурь түвшин-17.8 хувь, зорилтот түвшин 20 хувь, хүрсэн түвшин 15.4 хувь буюу 2025 оны нийт зах зээлийн үнэлгээний дээд үзүүлэлт 13.9 их наяд төгрөг, 2025 оны жилийн эцсийн урьдчилсан статистик мэдээгээр ДНБ 89.9 их наяд төгрөг, /Монголбанк/
- 1.12.4 “Шинжлэх ухааны парк” /зорилтот түвшин – 1, хүрсэн түвшин 0 буюу эрх зүйн орчин бүрдээгүй тул энэ ажил хийгдэх боломжгүй. /ЭЗХЯ/

Санхүүжилтээс шалтгаалсан:

- 4.1.16 “Судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь” зорилтот түвшин-0.2 хувь, хүрсэн түвшин-0.1 хувь, /Боловсролын яам/
- 1.12.1 “Хэрэгжүүлсэн судалгаа хөгжүүлэлтийн ажлын тоо” зорилтот түвшин-1650, хүрсэн түвшин-1254, /ЭЗХЯ/
- 1.12.3 “Хөтөлбөрт хамрагдсан судлаачид” /зорилтот түвшин-500, хүрсэн түвшин-0, ЭЗХЯ/ зэрэг хөтөлбөрүүд 2025 оны Улсын төсвийн тодотголоор шинжлэх ухааны салбарын төсөв 53.1 хувиар хасагдсанаас хэрэгжээгүй,
- 1.7.1 “Эрчим хүчний компаниудын санхүүгийн алдагдал” зорилтот түвшин-0 тэрбум төгрөг, Эрчим хүчний зохицуулах хорооноос хэрэглэгчийн цахилгаан, дулааны үнэ, тарифт өөрчлөлт оруулах шийдвэрийг 2024.11.01-ний өдрийн 632, 633 дугаар “Тариф батлах тухай” тогтоолоор баталсан. Засгийн газрын 2025.03.12-ны өдрийн “Олон улсын худалдааны тарифын нөхцөл

байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 132 дугаар тогтоолоор 2025 онд төлбөр, хураамжийг нэмэгдүүлэхгүй байх шийдвэр гарсан, хүрсэн түвшин – санхүүгийн алдагдал 180.0 тэрбум төгрөг. /ЭХЯ/

Шалгуур үзүүлэлтийг оновчгүй тодорхойлсон:

- 1.1.3 “Гадаад хөрөнгө оруулалтын хэмжээ” 2025 оны жилийн эцсийн статистик гараагүй ба 2025 оны 3-р улирлын дүнг өмнөх оны 3-р улирлын дүнтэй харьцуулахад 0.6 сая ам.доллаар багассан ба тус үзүүлэлт нь мөнгөн дүнгээр гардаг байхад хэмжих нэгжийг “хувь”-аар, /ЭЗХЯ/
- 1.11.4 “Газрын доройтлын хувь” суурь түвшин – 22.9 хувь, зорилтот түвшин – 22.9 хувь буюу өөрчлөлтийг хэмжигдэхүйц бус /БОУАӨЯ/ зэрэг төлөвлөлтийн алдаатай баталсан байна.

2.21. Дээрх хөтөлбөрүүд нь хариуцагч байгууллагын зохион байгуулалт, санхүүжилтийн бууралт, шалгуур үзүүлэлтийг оновчгүй тодорхойлсон зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан зорилтот түвшин хангагдаагүй, зарим үзүүлэлт суурь түвшнээс буурч, хэрэгжилтийн үр нөлөө хангалтгүй байна.

2.22. Эдийн засгийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах 167 төсөл, арга хэмжээний 189 шалгуур үзүүлэлтээс 111 төсөл, арга хэмжээний 123 шалгуур үзүүлэлт зорилтот үр дүнд хүрээгүй байна.

Хүснэгт 10. “Эдийн засгийн бодлого” тэргүүлэх чиглэлийн ТЕЗ-ийн үр дүнд хамаарах ТАХ-ний шалгуур үзүүлэлтийн тоо, үнэлгээний дундаж /хувиар/

№	ТЕЗ-ийн үр дүн	ТАХ-ний шалгуур үзүүлэлт	Үр дүн гарсан	Үр дүнгүй	Үнэлгээ /дундаж хувь/
1	Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	9	3	6	58.3
2	Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	15	5	10	55.4
3	Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоод хангамжийг нэмэгдүүлнэ.	8	3	5	58.2
4	Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	22	7	15	49.3
5	Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	28	10	18	44.9
6	Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	8	3	5	48.0
7	Эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангана.	29	10	19	46.6
8	Дөрвөн улирлын аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлнэ.	31	11	20	52.8
9	Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	4	2	2	61.3
10	Байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	5	1	4	26.6
11	Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	17	7	10	64.1
12	Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлнэ.	13	4	9	56.1
Нийт дүн		189	66	123	-

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.23. Дээрх төсөл, арга хэмжээний “үр дүнгүй” үнэлэгдсэн 111 ТАХ-ний 123 шалгуур үзүүлэлтээс 26 нь 61–84 хувь, 21 нь 31–60 хувь, 17 нь 1–30 хувиар үнэлэгдсэн ч, 59 шалгуур үзүүлэлт “0” хувьтай үнэлэгдсэн байна.

2.24. Үүнээс “Байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнгийн төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээ хамгийн бага буюу 26.6 хувьтай байна. Үүнд:

Зорилтот түвшнийг бодитой тодорхойлоогүй:

- 1.10.1.1 “Агаар, орчны бохирдлыг бууруулах ногоон төсөл, үйл ажиллагааг дэмжих” төсөл, арга хэмжээ 25000 айл өрхийг цахилгаан халаалтад бүрэн шилжүүлэхээр төлөвлөсөн ч хийгдсэн ажлын нотлох баримтгүй, /НЗДТГ/
- 1.10.1.1 “Агаар, орчны бохирдлыг бууруулах ногоон төсөл, үйл ажиллагааг дэмжих” төсөл, арга хэмжээ 15000 айл өрхийг хийн халаалтад бүрэн шилжүүлэхээр төлөвлөсөн ч Чингэлтэй дүүргийн 236 айл өрхөд хийн зуух суурилуулсан. /НЗДТГ/

Шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй:

- 1.10.1.1 “Ногоон зээлд хамрагдах, зээлийн үр өгөөж хүртэх иргэн, аж ахуйн нэгж байгууллага, айл өрх” Ногоон зээлд 2021-2024 оны хооронд 4,321.3 сая төгрөгийн зээлийг 485 зээлдэгчид олгосон ба 2025 онд хэрэгжих боломжгүй. /БОУАӨЯ/

Худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон:


- 1.10.2.2 “Байгаль орчны төв лабораторийн чадавхыг сайжруулах төслийг хэрэгжүүлэх”. /БОУАӨЯ/

2.25. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын аргачлалын дагуу тэргүүлэх чиглэлд хамаарах 167 төсөл, арга хэмжээний 189 шалгуур үзүүлэлтээс 66 шалгуур үзүүлэлт буюу 35 хувь нь “үр дүн гарсан”, 123 шалгуур үзүүлэлт буюу 65 хувь нь “үр дүнгүй” үнэлэгдсэн байна.

2.26. Үр дүнгүй үнэлэгдсэн 111 төсөл, арга хэмжээний 123 шалгуур үзүүлэлтээс 10 нь ТЭЗҮ, зураг төсөлгүй, 60 нь хариуцагч байгууллагын зохион байгуулалт болон гэрээ, хэлэлцээр удааширснаас, 26 нь төлөвлөлтийн алдаанаас, 27 нь санхүүжилтээс шалтгаалж зорилтот үр дүнг хангаагүй байна.

2.27. Эдийн засгийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах 189 шалгуур үзүүлэлт бүхий 167 төсөл, арга хэмжээнд нийт 12,113.9 тэрбум төгрөг төлөвлөснөөс 4,211.2 тэрбум төгрөг зарцуулсан байна. Эх үүсвэрээр нь задалж харуулбал:

Дүрслэл 3. “Эдийн засгийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах төсөл, арга хэмжээний эх үүсвэрийн задаргаа



Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.28. Эдийн засгийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах 167 төсөл, арга хэмжээнээс санхүүжилт шийдэгдээгүй шалтгаанаар 16 төсөл, арга хэмжээний 26 шалгуур үзүүлэлтээс 13 нь Засгийн газрын шийдвэр, гадаад зээл, хөрөнгө оруулалт шийдэгдээгүйгээс, 13 нь Улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй болон төсвийн өөрчлөлттэй холбоотой зэрэг шалтгаанаар зорилтод үр дүндээ хүрээгүй байна. Тухайлбал;

2025 оны Улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй:

- 1.8.3.11 “Налайх-Тэрэлж чиглэлийн 37 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх” 18.0 тэрбум төгрөг, /ЗТЯ/
- 1.5.1.8 “Ховд аймгийн Булган сумын Байтаг боомтыг байнгын ажиллагаатай боомт болгох” санхүүжих дүн тусгаагүй /БСҮХ/ гэх мэт.

2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр төсөв хасагдсан:

- 1.12.1.4 “Монгол судлалын үйл ажиллагааг дэмжих” 3.5 тэрбум төгрөг, /ЭЗХЯ/
- 1.12.2.1 “Шинжлэх ухаан, технологи болон аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг дэмжсэн үндэсний технологи дамжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх” 2.5 тэрбум төгрөг, шинжлэх ухаан, технологийн сангийн төсөв 53.1 хувиар хассан тул хэрэгжээгүй /ЭЗХЯ/ гэх мэт.

Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой:

- 1.7.1.1 “Эрчим хүчний өртөг шингэсэн тарифын тогтолцоог хэрэгжүүлж, санхүүгийн алдагдлыг зохистой түвшинд хүргэх” төсөл, арга хэмжээний 3 шалгуур үзүүлэлт нь МУЗГ-ын 2025 оны 132 дугаар тогтоолоор төлбөр, хураамжийг нэмэгдүүлэхгүй байх шийдвэр гарсан холбоотойгоор зорилтод үр дүнд хүрээгүй байна, санхүүжих дүн тусгаагүй, /ЭХЯ/
- 1.5.2.2 “Налайх-Замын-Үүд чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх” 336.0 тэрбум төгрөг санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Сангийн яам болон Азийн хөгжлийн банканд санал хүргүүлсэн ч шийдэгдээгүй /ЗТЯ/ гэх мэт.

Санхүүжилт шийдэгдээгүй:

- 1.7.2.2 “Байдрагийн усан цахилгаан станцын төслийг эхлүүлэх” 10.0 сая төгрөг, гадаад зээл, хөрөнгө оруулалт шийдэгдээгүй, хэлэлцээрийн шатанд явж байгаа, /ЭХЯ/
- 1.8.3.13 “Улаанбаатар-Лүн чиглэлийн авто замд байрлах Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх” 25.8 тэрбум төгрөг /ЗТЯ/ гэх мэт.

2.29. Эдийн засгийн бодлого тэргүүлэх чиглэлийн үнэлгээ 40.0 хувь, ТЕЗ-ийн үр дүнгийн дундаж үнэлгээ 39.5 хувь, Хөтөлбөрийн үр дүнгийн дундаж үнэлгээ 56.5 хувь, төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 53.8 хувь байна.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ - II

Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт болох аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоогоогүй байна.

2.30. Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлд 3 ТЕЗ-ийн үр дүн, 6 хөтөлбөрийн үр дүн, 58 шалгуур үзүүлэлт бүхий 53 төсөл, арга хэмжээний үр дүн хамаарч 2,010.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 11. Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ болон хөтөлбөрийн үр дүн, ТАХ-ний тоо, үнэлгээ

Үр дүнгийн нэр	Нийт үр дүн /тоо/	Нийт шалгуур үзүүлэлт /тоо/	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ			
			Үр дүн гарсан /тоо/	Үр дүнгүй /тоо/	Үнэлэх боломжгүй /тоо/	Дундаж үнэлгээ /хувь/
ТЕЗ-ийн үр дүн	3	3	1	2	-	46.7
Хөтөлбөрийн үр дүн	6	6	1	3	2	63.0
ТАХ-ний үр дүн	53	58	29	26	3	63.4
Нийт дүн	62	67	31	31	5	-

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.31. Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлийн хотын хөгжлийн индекс нь урьдчилсан гүйцэтгэлээр 43.4 хувьтай буюу үр дүнгүй, аймгуудын өрсөлдөх чадварын индекс шалгуур үзүүлэлт нь үнэлэх боломжгүй байна.

2.32. Аймгуудын өрсөлдөх чадварын индексийг “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв” ТББ нь Үндэсний статистикийн хорооноос тархаадаг 180 гаруй статистик мэдээ, иргэдийн санал асуулгад үндэслэн 2012 оноос хойш жил бүр гаргаж ирсэн ч 2024 оноос хойш холбогдох тайланг гаргаагүй байна.

2.33. Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- 2.1 “Орон нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх” үр дүнгийн шалгуур үзүүлэлт Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авдаггүй аймгийн тоо нэмэгдсэнээр үр дүн гарсан,
- 2.2 “Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах” үр дүнгийн шалгуур үзүүлэлт Нийслэлийн замын хөдөлгөөний дундаж хурдыг /оргил ачааллын үед/ 2025 онд 12 км/цаас 16 км/цагт хүргэхээр зорилтот түвшнийг тодорхойлсон ч дундаж хурд 11 км/цаг байх тул үр дүнгүй,
- 2.3 “Төвлөрлийг сааруулж, агаарын бохирдлыг бууруулах” үр дүнгийн шалгуур үзүүлэлт Улаанбаатар хотын агаар дахь РМ 2.5 тоосонцрын агууламжийг 31 Мкг/м3 болгон бууруулахаар байгаа боловч Цаг уур орчны шинжилгээний газраас гаргадаг агаарын чанарын хяналт шинжилгээний 2025 оны төлөв байдлын тайлангаар 37 Мкг/м3 байгаа тул үр дүнгүй байна.

2.34. Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах хөтөлбөрийн үр дүнг үнэлэх боломжгүй, үр дүнгүй дараах шалгуур үзүүлэлт байна. Тухайлбал;

- 2.1.1 “Орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх” хөтөлбөрийн Аймгуудын өрсөлдөх чадварын индексийн дундаж шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшнийг оновчтой тодорхойлоогүйгээс үнэлэх боломжгүй байна,
- 2.1.2 “Бүс, орон нутаг дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх” хөтөлбөрийн Орон нутгийн дэд бүтцийн хөгжлийн индексийн зөрүү шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүйгээс үнэлэх боломжгүй,
- 2.2.1 “Авто замын ачааллыг бууруулах” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт түгжрэлийн индексийн зорилтот түвшин 10, хүрсэн түвшин 7.5 буюу үр дүнгүй,
- 2.2.2 “Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт Нийслэлийн нийтийн тээврээр зорчдог хүн амын эзлэх хувь зорилтот түвшин 43, хүрсэн түвшин 40 буюу үр дүнгүй,

- 2.3.2 “Шинэ суурьшлын бүсэд инженерийн дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт Шинэ дагуул хотын цахилгаан хангамжийг 100.0 хувьд хүргэхээр зорьсон боловч 64.2 хувьтай үр дүнгүй байна.

2.35. Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах 53 төсөл, арга хэмжээний үр дүнгийн 58 шалгуур үзүүлэлтийн 29 буюу 50.0 хувь нь үр дүн гарсан, 26 буюу 44.8 хувь нь үр дүн гараагүй, 3 буюу 5.2 хувь нь үнэлэх боломжгүй байна.

2.36. Үр дүнтэй хэрэгжсэн дараах төсөл, арга хэмжээнүүд нийт олгогдсон санхүүжилтийн 75.6 хувийг эзэлж байна. Үүнд:

Гадаадын зээл, тусламжаар:

- 2.3.1.10 “Бага, дунд орлоготой иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн 5002 айлын “Солонго-I, II” орон сууцны хороолол” төслийг хэрэгжүүлэхэд 72.5 тэрбум төгрөг, /ХББОСЯ/
- 2.3.1.11 “1008 айлыг түр суурьшуулах орон сууц” төслийг хэрэгжүүлэхэд 40.0 тэрбум төгрөг, /ХББОСЯ/
- 2.3.1.20 “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих” төслийг хэрэгжүүлэхэд гадаадын зээлийн хөрөнгөөс 58.6 тэрбум, орон нутгийн хөрөнгөөс 24.6 тэрбум, нийт 83.2 тэрбум төгрөг. /НЗДТГ/

Улсын төсвийн санхүүжилтээр:

- 2.1.1.5 “Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж” төслийн 1 дүгээр үе шатыг гүйцэтгэхэд 18.0 тэрбум төгрөг, /ЭХЯ/
- 2.3.1.6 “Миний сонголт-Орон нутаг” хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй гурван хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг эхний гурван жилд хэрэгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх” 2023-2025 онд 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй ипотекийн зээлийг 5173 өрхөд 8.0 тэрбум төгрөгийн хүүгийн татаас, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан хүүгийн өгөөж болон хөрөнгө оруулалтын өгөөжийн зөрүү 35.5 тэрбум төгрөг, нийт 43.5 тэрбум төгрөгийг ХББОСЯ-ны урсгал зардлаас шилжүүлсэн байна. /ХББОСЯ/

Бусад эх үүсвэрээс:

- 2.3.1.7 “Миний анхны байр” ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх” нийт 1260.8 тэрбум төгрөгийн зээлийг 9894 өрхөд олгосон байна. /Монголбанк/

2.37. Хүрэх түвшнийг оновчтой тодорхойлоогүй, хариуцагч байгууллагын зохион байгуулалт, санхүүжилт шийдэгдээгүй, гэрээ хэлэлцээр удааширсан зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 2.1.1.2 “Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд ажиллах 100 МВт-ын хуримтлуурт усан цахилгаан станц барих төслийн бэлтгэл ажлыг хангах”, /ЭХЯ/
- 2.1.1.3 “Аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв барих”, /ЭХЯ/
- 2.1.1.6 “Зүүн бүсийг говийн бүстэй интеграцчилан хөгжүүлж, кокс, химийн бүтээгдэхүүн болон нүүрс-эрчим хүчний үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах ажлыг эхлүүлэх”, /АҮЭБЯ/
- 2.1.2.1 “Тавантолгой үйлдвэрлэл, технологийн парк түшиглэсэн Кокс-химийн цогцолбор үйлдвэрийн бэлэн байдлыг хангах”, /АҮЭБЯ/
- 2.1.2.2 “Алтанбулаг чөлөөт бүсийн ачаа тээвэр, барилгын материалын логиستيкийн төв байгуулах”, /ШСАА/
- 2.2.1.1 “Туулын авто замыг Нүхтийн авто замтай холбох Наадамчдын гудамжны 800 у/м гүүр барих”, /НЗДТГ/
- 2.3.1.5 “Миний амины орон сууц” хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх”, /ХББОСЯ/
- 2.3.1.17 “Гэр хорооллын хэсэгчилсэн болон бие даасан инженерийн хангамжийг нэвтрүүлэх “Дэд бүтцийн төв” шинээр байгуулах”, /НЗДТГ/
- 2.3.1.19 “Агаар, орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх”, /БОУАӨЯ/
- 2.3.2.2 “Засгийн газрын “Нэг цэг”-ийн үйлчилгээний цогцолборын зураг төсөв, барилга угсралтын ажлыг эхлүүлэх”, /ЗГХЭГ/
- 2.3.2.3 “Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээний бүтээн байгуулалтыг эхлүүлэх”. /ХББОСЯ/

2.38. Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах төсөл, арга хэмжээнд нийт 2,010.4 тэрбум төгрөгийг зарцуулснаас 1,269.7 тэрбум төгрөг буюу 63.2 хувь нь бусад эх үүсвэр, 495.8 тэрбум төгрөг буюу 24.7 хувь нь гадаадын зээл, тусламж, 235.4 тэрбум төгрөг

буюу 11.7 хувь нь улсын болон орон нутгийн төсөв, 9.6 тэрбум төгрөг буюу 0.5 хувь нь гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын эх үүсвэртэй байна.

2.39. Бүсчилсэн хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлээс ТЕЗ-ийн үр дүнгийн дундаж үнэлгээ 46.7 хувь, хөтөлбөрийн үр дүнгийн дундаж үнэлгээ 63.0 хувь, төсөл, арга хэмжээний 58 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 63.4 хувьтай байна.

ТЭРГҮҮЛЭХ
ЧИГЛЭЛ - III

НҮБ-ын 2025 оны “Хүний хөгжлийн үзүүлэлт”-ээр Монгол улс 104-д эрэмбэлэгдсэн байна.

2.40. Улс орнуудын Хүний хөгжлийн индексийг хамгийн сүүлд 2023 онд шинэчилсэн ба уг судалгааны суурь үзүүлэлтээр НҮБ-аас тайланг⁹ гаргасан байна.

2.41. Хүний хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлт “Хүний хөгжлийн үзүүлэлт”-ийг НҮБ-аас 4 жилд нэг удаа гаргадаг байна. Хүний хөгжил гэдэг нь хүмүүсийг өөрсдийн үнэ цэнтэй гэж үздэг амьдралаа эрх чөлөөтэй бүтээж амьдрах боломж олгоход чиглэдэг. Хүний хөгжлийн индекс нь дараах 3 үндсэн суурь үзүүлэлттэй.

Зураглал 1. Хүний хөгжлийн индексийн 3 үзүүлэлт



2.42. Хүний хөгжлийн индекс¹⁰ 2025 онд гараагүй, 2023 оны үр дүнд дэлхийн улс орнуудыг эрэмбэлэн НҮБ-аас /UNDP/ Хүний хөгжлийн үзүүлэлтийг /Human Development report-2025/ гаргасан ба Монгол Улсын хүний хөгжлийн индексийн тоон утга 2023 байдлаар 0.747 буюу нийт 193 улс орноос 104-д эрэмбэлэгдэж 8 эрэмбэ ухарсан байна.

2.43. НҮБ-аас 2025 оны “Хүний хөгжлийн үзүүлэлт”-д “Хиймэл оюуны эрин дэх

хүмүүсийн боломжууд” буюу Хиймэл оюун (AI) эрчимтэй хөгжиж буй энэ үед хүний хөгжил саарсан, Хүний хөгжлийн индексээр илэрхийлэгддэг олон арван жилийн ахиц дэвшил зогсонги байдалд орж, Ковид-19 цар тахал болон түүнээс хойших хямралуудын цохилтоос бүрэн сэргэж чадаагүй хэвээр байгаа талаар онцолсон байна.

2.44. Монгол Улсын Хүний хөгжлийн индексийг тооцох аргачлалыг 2014 онд батлан, Үндэсний статистикийн хорооноос жил бүр гаргадаг ба 2023 онд 0.753, 2024 онд 0.756 үзүүлэлттэй гарсан байна. 2025 оны статистикийн тархаах хугацаа болоогүй байна.

2.45. Хүний хөгжил бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах нийт 81 үр дүнгийн 112 шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 12. “Хүний хөгжлийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, Хөтөлбөр, ТАХ-ний нэгтгэл

Үр дүнгийн төрөл	Нийт үр дүнгийн тоо	Нийт шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ, тоо			
			Үр дүн гарсан	Үр дүнгүй	Үнэлэх боломжгүй	Дундаж үнэлгээ /хувь/
ТЕЗ-ийн үр дүн	8	22	16	4	2	87.5
Хөтөлбөрийн үр дүн	15	18	11	7	-	72.6
ТАХ-ний үр дүн	58	72	40	32	-	67.9
Нийт дүн	81	112	67	43	2	-

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.46. Хүний хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ-ийн 8 үр дүнгийн 22 шалгуур үзүүлэлтийг үнэлэхэд хариуцагч байгууллагын зохион байгуулалттай холбоотой, батлагдсан аргачлал, индекс байхгүй, мэдээллийг тархаах хугацаа болоогүй зэргээс үнэлэх боломжгүй, үр дүнгүй байна. Үүнд:

- 3.2 “Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ”, /Боловсролын яам/

⁹ “Human development report-2025, A matter of choice: People and possibilities in the age of AI

¹⁰ Хүний хөгжлийн индексийг 4 төрлөөр үнэлдэг бөгөөд 2025 онд маш өндөр түвшний хүний хөгжилтэй 74 улс, өндөр түвшний хүний хөгжилтэй 50 улс, дунд түвшний хүний хөгжилтэй 43 улс, бага түвшний хүний хөгжилтэй 26 улс байна.

- 3.2 “Нэг ээлжээр хичээллэх боломжтой төрийн өмчийн сургууль”, /Боловсролын яам/
- 3.8 “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь”, 2025 оны байдлаар ДНБ-д эзлэх хувь 0.6 байна, /ССАЖЗЯ/
- 3.3 “Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ” ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт болох “Хүүхдийн эрхийн индекс” батлагдаагүй, /ГБХНХЯ/
- 3.5 “Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн “Шинээр зохистой хөдөлмөр эрхэлсэн хүний тоо” шалгуур үзүүлэлтийг ҮСХ-ноос гаргадаагүй, суурь үзүүлэлтийн эх сурвалж тодорхойгүй, /ҮСХ/
- 3.1 “Зүрх судас, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчний шалтгаант нас баралтын түвшин” /30-70 нас/, 2025 оны статистик тархаах хугацаа болоогүй. /ЭМЯ/

2.47. Хүний хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах 15 хөтөлбөрийн үр дүнгийн 18 шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшнийг оновчтой тодорхойлоогүй, хариуцагч байгууллагын зохион байгуулалт хангалтгүй, санхүүжилт шийдэгдээгүй зэргээс шалтгаалж зорилтот үр дүнд хүрээгүй байна. Үүнд:

- 3.1.3 “Дотоодод худалдаалж байгаа эмийн чанарыг олон улсын стандартад нийцүүлнэ”, /ЭМЯ/
- 3.1.5 “Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлж, иргэдэд учрах чирээдлийг бууруулна”, /ЭМЯ/
- 3.3.1 “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна”, /ГБХНХЯ/
- 3.3.2 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний суурь эрхийг хангана”, /ГБХНХЯ/
- 3.4.2 “Төрийн албаны хүний нөөцийн тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ”, /ТАЗ/
- 3.6.1 “Иргэдийн соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ”, /ССАЖЗЯ/
- 3.1.1 “Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн тоог нэмэгдүүлнэ” /ЭМЯ/ гэх мэт.

2.48. Хүний хөгжлийн бодлого тэргүүлэх чиглэлд хамаарах 72 төсөл, арга хэмжээг шалгуур үзүүлэлт бүрээр үнэлэхэд “Үр дүнгүй” 32, “Үр дүн гарсан” 40 төсөл, арга хэмжээ байна.


Хүснэгт 13. Төсөл, арга хэмжээний дундаж үнэлгээ

№	ТЕЗ-ийн үр дүн	ТАХ-ний шалгуур үзүүлэлт	Үр дүн гарсан	Үр дүнгүй	Үнэлгээ /дундаж хувь/
1	Өвчлөл, нас баралтыг бууруулна.	24	13	11	67.8
2	Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна.	27	17	10	77.2
3	Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.	5	2	3	44.2
4	Нийгмийн баталгааг сайжруулна.	4	4	-	97.5
5	Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	5	2	3	79.2
6	Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4	1	3	32.5
7	Түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.	3	1	2	33.3
Нийт дүн		72	40	32	-

Эх сурвалж. Аудитын судалгааны нэгтгэл

2.49. Хэрэгжилт хангалтгүй буюу үр дүнгүй төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт хангагдаагүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Дүрслэл 4. “Хүний хөгжлийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах төсөл, арга хэмжээний хэрэгжээгүй шалтгаан



Эх сурвалж. Аудитын судалгааны нэгтгэл


2.50. Үр дүнгүй үнэлэгдсэн 32 төсөл, арга хэмжээнээс хэрэгжээгүй буюу “0” хувьтай үнэлэгдсэн 8, 30 хүртэлх хувьтай үнэлэгдсэн 8, 31.0-60.0 хувьтай үнэлэгдсэн 9, 61.0-84.0 хувьтай үнэлэгдсэн 7 шалгуур үзүүлэлт байна.

2.51. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд Төрийн захиргааны төв байгууллагын хүргүүлсэн саналыг өөрчилж тухайн жил хэрэгжүүлэх боломжгүй шалгуур үзүүлэлтээр баталсан, бодлогын зорилго, хуулийн зохицуулалттай нийцээгүй, урьдчилсан судалгаанд суурилаагүй хэрэгжихүйц бус арга хэмжээ төлөвлөсөн байна. Тухайлбал;

- 3.1.2.5 “Бүсүүдэд лавлагаа шатлалын эмнэлэг барих төслийн бэлэн байдлыг хангаж, эхлүүлэх”, /ЭМЯ/
- 3.3.1.2 “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв байгуулах, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх”, /ГБХНХЯ/
- 3.3.1.3 “Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлэх”, /ГБХНХЯ/
- 3.1.2.8 “Монгол Улсад оношлогдох, эмчлэгдэх боломжгүй өвчний чиглэлээр технологи нэвтрүүлэх” /ЭМЯ/ гэх мэт.

2.52. “Хүний хөгжлийн бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах төсөл, арга хэмжээнд төлөвлөгдсөн 1,861.9 тэрбум төгрөгөөс 917.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

Дүрслэл 5. “Хүний хөгжлийн бодлого” тэргүүлэх чиглэлийн төсөл, арга хэмжээний эх үүсвэрийн задаргаа



Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.53. Үр дүнд хүрээгүй 33 төсөл, арга хэмжээнээс санхүүжилт 15 төсөл, арга хэмжээ нь 46.9 хувийг эзэлж байна. Тухайлбал;

- 3.1.5.1 “Эрүүл мэндийн салбарын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх” /ЭМЯ/,
- 3.6.1.1 “Бүх нийтийн соёлын боловсрол II” арга хэмжээ хэрэгжүүлэх” /ССАЖЗЯ/,
- 3.7.1.2 “Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын хүчитгэлийг хийж гүйцэтгэх” /ССАЖЗЯ/,
- 3.7.1.3 “Улсын драмын эрдмийн театрын хүчитгэлийг хийж гүйцэтгэх” /ССАЖЗЯ/,
- 3.2.1.10 “Халаалтын урсгал зардал өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэх, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй технологид шилжүүлэх, бэлтгэл хангах” /Боловсролын яам, ХББОСЯ/ гэх мэт.

2.54. Төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хэрэгжилт, үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай хөрөнгийг бүрэн тооцоолох шаардлагатай байна.

ТЭРГҮҮЛЭХ
ЧИГЛЭЛ - IV

“Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлийн “авлигын индекс” 2025 онд 124 дүгээрт эрэмбэлэгдэж зорилтот үр дүнд хүрээгүй байна.

2.55. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд 6 шалгуур үзүүлэлт бүхий 6 ТЕЗ-ийн үр дүн, 24 шалгуур үзүүлэлт бүхий 12 хөтөлбөрийн үр дүн, 54 шалгуур үзүүлэлт бүхий 54 төсөл, арга хэмжээний үр дүн хамаарч байна.

Хүснэгт 14. “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ, Хөтөлбөр, ТАХ-ний үр дүнгийн нэгтгэл


№	Үзүүлэлт	Нийт үр дүн /тоо/	Нийт шалгуур үзүүлэлт /тоо/	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ			
				Үр дүн гарсан /тоо/	Үр дүнгүй /тоо/	Үнэлэх боломжгүй /тоо/	Дундаж үнэлгээ /хувь/
1	ТЕЗ-ийн үр дүн	6	6	2	3	1	38.6
2	Хөтөлбөрийн үр дүн	12	24	13	10	1	59.3
3	ТАХ-ний үр дүн	54	54	24	30	-	63.2
Нийт дүн		72	84	39	43	2	-

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.56. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд 6 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 6 ТЕЗ-ийн үр дүн 38.6 хувь, 10 байгууллагын

хариуцан хэрэгжүүлсэн 24 хөтөлбөрийн үр дүн 59.3 хувь, 14 байгууллагын хариуцан хэрэгжүүлсэн 54 төсөл, арга хэмжээний үр дүн 63.2 хувийн биелэлттэй зорилтот үр дүнг хангасан байна.

Дүрслэл 6. “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТЕЗ-ийн үр дүн (шалгуур үзүүлэлтээр)




Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.57. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд 6 ТЕЗ-ийн үр дүнгээс “4.4 Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ”, “4.5 Хилийн аюулгүй байдлыг хангана” хөтөлбөрийн хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн бол дараах ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал;

- 4.1 “Шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнгийн “судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь” шалгуур үзүүлэлтийн биелэлт 2025 оны улсын төсвийн зардлын хуваарилалтад 115.0 сая төгрөг батлагдсан ч 2025 оны улсын төсвийн тодотголоор эрдэм шинжилгээ, судалгааны зардал 53.1 хувиар буурч хүрч үр дүнд хүрээгүй,
- 4.2 “Шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ” ТЕЗ-ийн үр дүнг хариуцагч байгууллагыг “хүний эрхийн үндэсний комисс” гэж буруу тодорхойлж, чиг үүргийн бус байгууллагад хариуцуулж баталснаас шалтгаалж үр дүн гараагүй,
- 4.3 “Авлигын гэмт хэргийг бууруулна” ТЕЗ-ийн үр дүнг “авлигын төсөөллийн индекс” шалгуур үзүүлэлтийн биелэлт 2024 онд 114 дүгээр байранд эрэмбэлэгдэж байсан бол 2025 онд 124 дүгээр байранд эрэмбэлэгдэж 10 байраар ухарсан тул үр дүнд хүрээгүй,
- 4.6 “Орчны аюулгүй байдлыг хангана” ТЕЗ-ийн үр дүнг хариуцах байгууллагаар ХББОСЯ болон БОУАӨЯ-аар баталсан бөгөөд үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалын дагуу Байгаль орчны салбарын хүрээнд 19 маягтаар байгаль орчны болон “ардчилсан засаглал судалгаа”-ны статистик мэдээллийг тархаах хугацаа болоогүй тул үнэлэх боломжгүй байна.

2.58. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд 24 хөтөлбөрийн үр дүнгээс 13 хөтөлбөр үр дүн гарсан. Харин 10 хөтөлбөр үр дүнд хүрээгүй, 1 хөтөлбөрийн үр дүнг үнэлэх боломжгүй байна.

Дүрслэл 7. “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах хөтөлбөрийн үр дүн



Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.59. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого тэргүүлэх чиглэлд санхүүжилт шийдвэрлээгүй, хүрэх түвшнийг оновчтой тодорхойлоогүй, зохион байгуулалт, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаатай холбоотой үр дүнгүй үнэлэгдсэн хөтөлбөрийн үр дүн байна. Үүнд:

Санхүүжилт шийдвэрлээгүй:

- 4.1.1 “Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулна” хөтөлбөрийн үр дүнгийн “шинэ бүтээл”, “Бүтээгдэхүүний загварын патент” зэрэг 2 шалгуур үзүүлэлт, /ЭЗХЯ/

- 4.5.1 “Хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгийн “Монгол Улсын агаарын хил, орон зайн хяналтын түвшин” шалгуур үзүүлэлт. /БХЯ/

Хүрэх түвшнийг оновчтой тодорхойлоогүй:


- 4.1.1 “Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулна” хөтөлбөрийн үр дүнгийн “судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь” шалгуур үзүүлэлт, /Боловсролын яам/
- 4.1.2 “Мэдээлэл, харилцаа холбооны хатуу, зөөлөн дэд бүтцийг өргөтгөж, сайжруулна” хөтөлбөрийн үр дүнгийн “арга хэмжээний хэрэгжилт”, “үүрэн холбооны сүлжээ нэмэгдэх баг”, “сэлгэн ажиллах дэд төв” зэрэг 3 шалгуур үзүүлэлт, /ЦХИХХЯ/
- 4.6.2 “Орчны чанарыг стандарт түвшинд хүргэнэ” хөтөлбөрийн үр дүнгийн “агаарын чанарын стандартаас давсан бохирдолтой хот суурин газар”, “усны чанарын индексээр маш бохир, бохир зэрэглэлтэй цэг” зэрэг 2 шалгуур үзүүлэлт. /БОУАӨЯ/

Зохион байгуулалт, хамтран хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаатай холбоотой:

- 4.6.3 “Хүн, нийгмийн амар тайван байдлыг хангана” хөтөлбөрийн үр дүнгийн “Хууль, эрх зүйн салбарын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ” шалгуур үзүүлэлт, /ХЗДХЯ/
- 4.6.4 “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ” хөтөлбөрийн үр дүнгийн “арга хэмжээний хэрэгжилт” шалгуур үзүүлэлт. /ГХЯ/

2.60. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд 54 ТАХ-ний үр дүнгээс 24 төсөл, арга хэмжээний үр дүн гарсан. Харин 30 төсөл, арга хэмжээ үр дүнд хүрээгүй байна.

Дүрслэл 8. “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлд хамаарах ТАХ-ний үр дүн




Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.61. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд “Үр дүнгүй” буюу “0” хувьтай үнэлэгдсэн дараах төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- 4.1.2.2 “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуулын төслийг хэрэгжүүлэх” ТАХ-ний үр дүнгийн “төслийн хэрэгжилт” шалгуур үзүүлэлт, /ЦХИХХЯ/
- 4.1.2.5 “Аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх” ТАХ-ний үр дүнгийн “төслийн хэрэгжилт” шалгуур үзүүлэлт, /ЦХИХХЯ/
- 4.1.2.9 “Мэдээлэл технологийн хаб байгуулах” ТАХ-ний үр дүнгийн “байгуулсан төв” шалгуур үзүүлэлт, /ЦХИХХЯ/
- 4.1.2.10 “Сэлгэн ажиллах дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгох” ТАХ-ний үр дүнгийн “сэлгэн ажиллах дэд төв” шалгуур үзүүлэлт, /ЦХИХХЯ/
- 4.1.2.11 “Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа төрийн тусгай байгууллагуудын харилцаа, холбооны систем, тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх” ТАХ-ний үр дүнгийн “төслийн хэрэгжилт” шалгуур үзүүлэлт, /ХЗДХЯ/
- 4.1.2.13 “Монгол Улсын GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээг өтгөрүүлэх” ТАХ-ний үр дүнгийн “арга хэмжээний хэрэгжилт” шалгуур үзүүлэлт, /ГЗБГЗЗЕГ/
- 4.6.1.7 “Цаг уурын радарын улсын сүлжээг байгуулах” ТАХ-ний үр дүнгийн “радарын станц байлуулах аймаг” шалгуур үзүүлэлт, /БОУАӨЯ/
- 4.6.3.2 “Кибер аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлэх” ТАХ-ний үр дүнгийн “мэдээллийн аюулгүй байдлын талаарх гадаад, дотоод аудитын үнэлгээ” шалгуур үзүүлэлт. /ШЕЗ/

2.62. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого тэргүүлэх чиглэлийн хүрээнд 54 төсөл, арга хэмжээний санхүүжилт 736.2 тэрбум төгрөгөөр батлагдаж 238.8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Үүнд:

Дүрслэл 9. “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” тэргүүлэх чиглэлийн хүрээнд зарцуулсан хөрөнгийн мэдээлэл



Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.63. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого тэргүүлэх чиглэл нь хоёр шалгуур үзүүлэлттэй бөгөөд “авлигын индекс” шалгуур үзүүлэлтийн хувьд 2023 онд 121, 2024 онд 114 дүгээр байранд эрэмбэлэгдэж байсан бол 2025 онд 124 дүгээр байранд эрэмбэлэгдэж зорилтот үр дүнг хангаагүй байна. Харин “дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж” шалгуур үзүүлэлтийн биелэлтийн статистик тоон үзүүлэлт гарах хугацаа болоогүй шалтгаанаар үнэлэх боломжгүй байна.

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэгчид “хугацаа болоогүй” гэж тайлагнасан байна.

2.64. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хариуцагч байгууллагаас “ХБ” буюу хугацаа болоогүй гэсэн тайлбараар үнэлээгүй байна. Үүнд:

Хүснэгт 15. ТЕЗ-аас ХБ буюу хугацаа болоогүй үнэлэгдсэн ТАХ-г ЗГХХГ болон УАГ-аас үнэлсэн харьцуулалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	ТЕЗ-ийн нэр	Үнэлгээ		
			ТЕЗ	ЗГХХГ	УАГ
1	1.1.1.2.Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийг хэрэгжүүлэх/	ЭЗХЯ	ХБ	100	87.5
2	1.1.3.1. Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс мэдээ мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх цогц үйлчилгээг тогтворжуулах	ШСАА	ХБ	100	100
3	1.2.1.3.“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн нэмэлт санхүүжилт II төслийг хэрэгжүүлэх	ХХААХҮЯ	ХБ	100	30.0
4	1.2.1.4.“Мал аж ахуйн шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн эко парк”-ийг байгуулах хувийн хэвшлийг дэмжиж, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлэх	ХХААХҮЯ	ХБ	100	50.0
5	2.2.1.2. “Сэлбэ сэргэлт” төслийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	НЗДТГ	ХБ	63.0	70.0
6	2.3.1.1.Инженерийн дэд бүтцийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх	ХББООСЯ	ХБ	30.0	30.0
7	4.3.1.1.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх/	АТГ	ХБ	0.0	66.0

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл /тайлбар: ХБ-хугацаа болоогүй./

2.65. Хариуцагч байгууллагын үнэлээгүй буюу “хугацаа болоогүй” гэж тайлагнасан дээрх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг аудитаар нотлох баримтад үндэслэн үнэллээ.

2.66. Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд ЗГХХГ-аас үнэлгээ хийхдээ зарим арга хэмжээний нотлох баримтыг дутуу бүрдүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд үндэслэсэн байна. Тухайлбал;

- 3.2 “Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна” ТЕЗ-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт-Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж 58.6 хувь буюу зорилтот үр дүнд хүрсэн,
- 4.6.2 “Орчны чанарыг стандарт түвшинд хүргэнэ.” Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт-Хөрсний чанарын стандартаас давсан бохирдолтой цэгийн тоо 30 буюу зорилтот үр дүнд хүрсэн,
- 2.1.2.5 “Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх” төслийн хэрэгжилт 7.1 хувь буюу зорилтот үр дүнд хүрсэн байхад ЗГХХГ-аас 0 хувь гэх мэт.

2.67. Засгийн газрын хяналт, хэрэгжүүлэх газар болон Төсвийн ерөнхийлөн захирагч нар Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 4.1¹¹, 4.2¹²-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.68. Монгол Улсын хөгжлийн 2023, 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар 2023 онд 6 зөвлөмж, 2024 онд 12 зөвлөмж тус тус өгсөн байна.

Хүснэгт 16. Аудитаар өгсөн зөвлөмжийн мэдээлэл

№	2023 он	Зөвлөмжийн тоо	2024 он	Зөвлөмжийн тоо
1	Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	2	Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	4
2	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарт	2	Монгол Улсын Засгийн газар болон Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт	4
3	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд нарт	1	Сангийн сайд	1
4	Төсвийн ерөнхийлөн захирагч нарт	1	Төсвийн ерөнхийлөн захирагч нарт	3

Эх сурвалж: УАГ-ын Монгол Улсын 2023, 2024 онуудын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн үр дүнгийн аудитын тайлан

2.69. Монгол Улсын хөгжлийн 2023, 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар 2023 онд 22 ТЕЗ, 2024 онд 18 ТЕЗ-д зөвлөмж, АҮЭБЯ-нд 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

2.70. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрд гурван зөвлөмж өгсөн бөгөөд үүнээс албан бичгээр хэрэгжилт ирүүлсэн 9 ТЕЗ-ийн зөвлөмжийн биелэлтийн дундаж үнэлгээ 80.2 хувьтай байна.

Хүснэгт 17. Зөвлөмжийн биелэлтийн дундаж үнэлгээ

№	Хэрэгжилт ирүүлсэн ТЕЗ нарын нэр	Зөвлөмж 1	Зөвлөмж 2	Зөвлөмж 3	Дундаж	Ирүүлсэн албан бичгийн огноо, дугаар
1	Боловсролын яам	60	100	0	53.3	2026.01.26 02/361
2	БХЯ	100	100	0	66.7	2026.02.10 16/532
3	ЗТЯ	100	100	100	100.0	2026.01.22 03/350
4	ХББОСЯ	100	100	90	96.7	2026.01.15 02/193
5	ХЗДХЯ	100	100	100	100.0	2026.01.20
6	ССАЖЗЯ	100	0	65.8	55.3	2026.01.12 01/78
7	ЭХЯ	100	100	100	100.0	2026.02.04 в/471
8	НЗДТГ	100	100	50	83.3	2026.01.27 03/481
9	Сангийн яам	100	100	0	66.7	2026.12.26 01/11246
Биелэлтийн дундаж		95.6	88.9	56.2	80.2	-

Эх сурвалж: Аудитын судалгааны нэгтгэл

2.71. Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтийг ирүүлэхдээ албан бичгээр, холбогдох нотлох баримтын хамт ирүүлэх шаардлагатай боловч холбогдох нотлох баримтыг бүрэн ирүүлэхгүй байна.

2.72. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ирүүлээгүй, нотлох баримт хангалтгүй байгаа нь бодлогын баримт бичигт хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээ төлөвлөлтийн алдаатай батлагдах, үр дүнгүй байх, үнэлгээнд ахиц гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байгаа тул цаашид зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах шаардлагатай байна.

¹¹ 4.1. Байгууллага дараах эрх, үүрэгтэй байна

¹² 4.2. Хяналт хэрэгжүүлэх газар дараах эрх, үүрэгтэй байна

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 128 төсөл, арга хэмжээ, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 169 зорилтыг Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан байна.
2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд Улсын төсвийн эх үүсвэрээс санхүүжихээр батлагдсан 160 төсөл, арга хэмжээнээс 86 төсөл, арга хэмжээ буюу 53.7 хувийн санхүүжилт улсын төсөвт тусгагдаагүй.
3. Улсын хөгжлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт оновчгүй, хэмжих нэгж уялдаагүй, суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус, суурь түвшин алдаатай, хариуцагч байгууллагыг буруу тодорхойлсон, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөвгүй арга хэмжээг төлөвлөх зөрчил давтагдсаар байна.
4. Улсын хөгжлийн жилийн 2025 оны төлөвлөгөөнд батлагдсан 328 төсөл, арга хэмжээний 373 шалгуур үзүүлэлтийн дундаж үнэлгээ 58.1 хувь, хөтөлбөрийн үр дүнгийн дундаж үнэлгээ 62.0 хувь, ТЕЗ-ийн үр дүнгийн дундаж үнэлгээ 63.7 хувь, тэргүүлэх чиглэлийн дундаж үнэлгээ 20.9 хувиар тус тус үнэлэгдлээ.
5. Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 328 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай 19,359.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн 37.9 хувь буюу 7,336.4 тэрбум төгрөгийг 184 арга хэмжээнд зарцуулсан байна.
6. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээнд урьдчилсан судалгаа хийгээгүй, төслийг түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжгүй, төлөвлөлтийн алдаатай, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй арга хэмжээнүүд төлөвлөсөн, хэрэгжилт хангалтгүй байна.
7. Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 тэргүүлэх чиглэл, 3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон 5 хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийг Монгол Улсын 2025 оны үндэсний статистик тоон мэдээлэл үзүүлэлт болон олон улсын байгууллагаас гаргадаг холбогдох тайлан гарах хугацаа болоогүйгээс шалтгаалж үнэлэх боломжгүй байна.
8. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-д заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Эдийн засаг, хөгжлийн яаманд:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан төсөл, арга хэмжээнд тавих шаардлагад нийцүүлэн, тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэмбэлэн боловсруулах;
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хариуцагч байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшнийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлох;

Сангийн сайдад:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэл барьж, төсвийн төлөвлөлтийг уялдуулах;

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийн тооцоо, судалгаанд үндэслэн бодитой, хэмжигдэхүйц тодорхойлох;
2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан хариуцан хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу нотлох баримтад үндэслэн бодитой үнэлж, үр дүнг үнэн зөв тайлагнах;
3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн төсөл, арга хэмжээний зорилтот түвшнийг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт:

1. Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмыг бүрэн хэрэгжүүлж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ хийх, дүнг нэгтгэх, үнэлгээ хийхдээ нотлох баримтад үндэслэн үнэлж, хэрэгжилтийн үр дүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг тодорхойлон тайлагнах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026. 03. 05 № ҮХГ/717
танай _____-ны № _____-т

**Тайлангийн төсөлд санал,
тайлбар хүргүүлэх тухай**

Танайхаас ирүүлсэн "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний
гүйцэтгэлд аудит хийсэн тайлантай танилцаад санал, тайлбарыг хавсралтаар
хүргүүлж байна.

Хавсралт 16 хуудастай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР С.МАГНАЙСҮРЭН
ТАНАА**

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ



**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД**

Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, Самбуугийн гудамж,
Засгийн газрын 11-р байр
Утас: 51263333, Факс: 51263333
Цахим шуудан: info@med.gov.mn
Цахим хуудас: www.med.gov.mn

2026.03.06 № 01/530
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

"Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн төсөлтэй холбогдуулан Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн
засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын
хүрээнд холбогдох санал, тайлбарыг нэгтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 16 хуудастай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР С.МАГНАЙСҮРЭН
ТАНАА**



Эдийн засаг, хөгжлийн яам
Удирдлага
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг,
хөгжлийн сайд
Жадамба Энхбаяр

Улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт



САНАЛ, ТАЙЛБАР

1. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд аудит хийсэн тайлан дараах өөрчлөлтийг тусгах саналтай байна. Үүнд:

- Тайлангийн нүүр хэсэгт "Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй, батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна" гэснийг "Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл, арга хэмжээний хэрэгжилт 61 хувийн гүйцэтгэлтэй байна" гэж;
- Мөн тайлангийн АГУУЛГА хэсэг, 10 дугаар хуудаст "ГУРАВ.НҮБ-ын 2025 онд хийсэн "Хүний хөгжлийн үзүүлэлт"-ээр Монгол Улс 104-т эрэмбэлэгдэж 8 эрэмбэ ухарсан байна." гэснийг "ГУРАВ.НҮБ-ын 2025 онд хийсэн "Хүний хөгжлийн үзүүлэлт"-ээр Монгол Улс 104-т эрэмбэлэгдсэн байна." гэж;
- Мөн тайлангийн АГУУЛГА хэсэгт "ДӨРӨВ. "... 2025 онд 124 дүгээрт эрэмбэлэгдэж зорилт үр дүнд хүрээгүй..." гэснийг "... 2025 онд 124 дүгээрт эрэмбэлэгдсэн байна..." гэж тус тус өөрчлөх;
- Тайлангийн 10 дугаар хуудаст "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр санхүүжүүлэхээр батлагдсан 32 төсөл, арга хэмжээний 81.3 хувь үр дүнгүй байна" гэснийг хасах (ЗЗХЯ-ны тайлбар 2.6);
- Тайлангийн 6 дугаар хуудаст "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд ТЭЗҮ-ий 22 төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна." гэж, тайлангийн 7-8 хуудаст дурдсан төлөвлөлтийн алдаатай гэж үзсэн арга, хэмжээ, шалгуур үзүүлэлтийг дахин нягталж үзэх;
- Мөн тайлангийн агуулгад улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан үр дүнтэй хэрэгжсэн төсөл, арга хэмжээний мэдээллээс нэмж тусгах.

2.Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн санал, тайлбар:

№	Аудитын тайлангийн төсөл	Санал, тайлбар
1.10	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлтийн суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус байна.	Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/167 дугаар тушаалаар баталсан "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу төсөл, арга хэмжээний өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшнийг тодорхойлсон.
1.13	Шалгуур үзүүлэлт өнөөгүйг тодорхойлсон: 1.7.3.3.Багануурын цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх Шалгуур үзүүлэлт: Барилгын ажлын гүйцэтгэл	2024 онд барилга угсралтын ажлыг эхлүүлэн гүйцэтгэлийг 20%-д хүргэх, 2025 онд 40%-д хүргэхээр төлөвлөж, шалгуур үзүүлэлтийг "Барилгын ажлын гүйцэтгэл" гэж тодорхойлсон.

2.1.2.1	Тавантолгой үйлдвэрлэл, технологийн парк түшиглэсэн Кокс-химийн үйлдвэрийн болон байдлыг хангах. Шалгуур үзүүлэлт: Барилгын ажлын гүйцэтгэл	1.Кокс үйлдвэрлэл, дайвар бүтээгдэхүүнийг ашиглаж эрчим хүч боловсруулах кокс-эрчим хүчний үйлдвэр, 2.Нүүрсний баяжмалыг боловсруулж кокс, дайвар бүтээгдэхүүн болох хий, давирхай үйлдвэрлэх кокс-химийн үйлдвэрийг бүтээн байгуулалтын ажлыг 20 хувьд хүргэхээр төлөвлөж, шалгуур үзүүлэлтийг "Барилгын ажлын гүйцэтгэл" гэж тодорхойлсон.
1.13	Суурь болон зорилтот түвшин хэмжигдэхүйц бус баталсан: 4.6.1.9.Аймаг, нийслэлийн хэмжээнд 2002 оноос өмнөх гийт барилга байгууламжийг паспортжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх. Шалгуур үзүүлэлт: Шинээр паспортжуулах барилга Суурь түвшин: 944 Зорилтот түвшин: 100 3.1.4 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийг боловсронгуй болгоно. Шалгуур үзүүлэлт: Шинэчилсэн аргачлал Суурь түвшин: 3 Зорилтот түвшин: 3	2024 оны байдлаар паспортжуулсан барилга байгууламжийн тоо 944 байгаа бөгөөд 2025 ойд буюу тухайн онд нэмж 100 барилга байгууламжийн газар хөдөлтийн тэсвэрлэх чадварыг тодорхойлж, паспортжуулахаар төлөвлөсөн. Тус зорилтын хүрээнд тухайн онд буюу 2025 онд 3 аргачлал шинэчилэн батлуулж анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон амбулатори, өдрийн эмчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас түлхүү санхүүжүүлэх, шаварлагагүй эмнэлэгт хэвтэлт, онкологичлалт бууруулах зэргээр салбарын санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.
1.13	Суурь түвшин алдаатай баталсан: 3.1.2.1. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад алсын зайн анагаах ухаан (телемедицин)-ыг хөгжүүлэх. Шалгуур үзүүлэлт: Телемедицин нэвтрэх эрүүл мэндийн байгууллага (тоо) Суурь түвшин: 250 Зорилтот түвшин: 260	Тус мэдээлэл нь хүний эмзэг мэдээлэлд хамаарах тул Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түнхий удирдлагын тухай хуулийн 9.4.5-д "Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай мэдээлэл, судалгаа, тодорхой салбарын хөгжлийн асуудлаар санал, дүгнэлт, төлөвлөгөөний төслийг төрийн бүх шатны байгууллага болон холбогдох бусад байгууллагаас гаргуулан авах; гэсний дагуу 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1а/300 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн яамны санал, тооцооллыг үндэслэн суурь болон зорилтот түвшнийг тодорхойлсон. Тухайн онд 30 эрүүл мэндийн төвд телемедицин нэвтрүүлж зорилт тавьсан.
1.13	Хариуцагч байгууллагаг буруу тодорхойлсон:	2025 оны хөгжлийн төлөвлөгөөг Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түнхий удирдлагын тухай хуулийг баримтлан боловсруулсан бөгөөд тус хуулийн 9.6.2-т зааснаар төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд баримт бичигт тусгах саналаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн агуулгад арилхсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

1.16	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд ТЭЗҮ-ий төсөл, арга хэмжээг тусгаж баталсан	Мөн хуулийн 6.10.2-т тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь хариуцах эзэнтэй байх шаардлагатай гэж тус тус зохицуулсан байдаг. Иймд "Хариуцагч байгууллагаг буруу тодорхойлсон" гэж дүгнэлтийг хийхдээ тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх саналыг холбогдох байгууллагаас тухайн онд албан бичгээр ирүүлсэн эсэх, өөрийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой гэж тодорхойлсон эсэхийг ирүүлсэн албан бичиг, баримтад тулгуурлан нягтлах нь зүйтэй. Хэрэв холбогдох байгууллагаас тухайн онд хэрэгжүүлэх саналыг албан ёсоор ирүүлсэн нь баримтаар нотлогдож байгаа тохиолдолд "хариуцагч байгууллагаг буруу тодорхойлсон" гэж дүгнэлт нь хууль зүйн үндэслэлгүй гэж үзэх боломжтой юм.
2.6	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8.1.2-т "урьдчилсан үнэлгээ хийсэн, түншлэлээр хэрэгжүүлэх төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түнхий удирдлагын тухай хуульд заасны дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах" гэж заасны дагуу Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг тусган баталж байгаа боловч батлагдсан зарим төсөл, арга хэмжээнд урьдчилсан шинжилгээ хийгээгүй, Төр хувийн хэвшлийн төвийн дүгнэлтээр төслийг хэрэгжүүлэхэд тохиромжгүй, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагагүй зэрэг нийтлэг төлөвлөлтийн алдаатай, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй арга хэмжээнүүдийг баталсан байна.	Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-нд санхүүжилтийн эх үүсвэрийн ангиллаар Төр, хувийн хэвшлийн түншлэл болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр 32 төсөл, арга хэмжээг тусгасан. Уг 32 төсөл, арга хэмжээнээс "Гашуунсухайт-Ганцмод боомтод хил дамнансан 18.9 км төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминал барих" төслийн тухайд "Эрдэнэс тавантолгой" ХК хариуцан санхүүжүүлэхээр болсон бол Нийслэлээс хэрэгжүүлэхээр төлөвлөж буй их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро байгуулах төсөл"-ийн эх үүсвэрийг олон улсын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр болсон. "Монгол Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-нд түншлэлээр хэрэгжүүлэхээр туссан үлдсэн төсөл, арга хэмжээнүүдийн тухайд "Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой Барууран чиглэлийн 32 км авто замын төсөлөөс "Цагаандол уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам барих төсөл"-ийн

2.15	Тэргүүлэх чиглэлийн 4 бодлогыг үнэлэх 6 шалгуур үзүүлэлт батлагдсанаас 2 шалгуур үзүүлэлт нь Монгол Улсын 2025 оны үндэсний хэмжээний зарим статистик тоон мэдээлэл үзүүлэлт болон олон улсын	Барилгын ажлын хугацааг 2025 оны 2 дугаар улиралд багтаан эхлүүлэхээр төлөвлөж байсан боловч "Цагаандол уул" боомт нэхэх, авто зам барихыг эсэргүүцсэн орон нутгийн иргэдийн эсэргүүцэл зэргээс шалтгаалан хошигшиж, 2025 оны 11 дүгээр сараас зам барилгын ажлыг эхлүүлэн 2027 оны 2 дугаар сард ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. "Өмнөговь аймгийн Төв-Төвийн Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто зам барих төсөл"-ийн тухайд гүйцэтгэл 83.1 хувьтай, 2026 оны 9 дүгээр сард ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор баталсан "Түншлэлээр хэрэгжүүлэх бүрэн шинжилгээ хийх журам"-д салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь "дээрх журмын хавсралтад тусгагдсан "Маяг 1-8"-д заасан мэдээлэлд болон төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо, санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ, урьдчилсан үнэлгээнд шаардлагатай бусад мэдээлэл"-ийг агуулсан төслийн саналыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэхээр заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдаас 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн "Төслийн санал ирүүлэх тухай" 01/271 тоот албан бичгийг бүх хямдад хүргүүлсэн. Уг албан бичгийн хүрээнд "Монгол Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-нд туссан төслүүдээс 7 төсөлд урьдчилсан үнэлгээ хийлгэхээр санал ирүүлснээс 5 төсөлд урьдчилсан үнэлгээг холбогдох журмын дагуу хийж, түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжгүй гэсэн дүгнэлт гарсан тул төсөл санаачлагчид буцаасан. Харин үлдсэн 19 төсөлд салбар яамдаас төслийн санал ирүүлээгүй. Арсуурь-Шивээхүрэн-Нарийсухайт чиглэлийн 1255 км төмөр замын хүрээнд "Шивээхүрэн-Нарийсухайт-Шинэжиаст чиглэлийн 300 км төмөр зам барих төсөл"-ийн хувьд бүрэн шинжилгээний явцад холбогдох судалгаа дууту хийгдсэн шалтгаанаар төсөл санаачлагчид буцаасан. "Эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэл"-ийн хүрээнд эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэх зорилтот түвшнийг тусгагдсан хэдий ч 2025 оны жилийн эдийн урьдчилсан гүйцэтгэлээр 6.8 хувийн өсөлтийг буюу төлөвлөсөн зорилтот түвшнээс 1.2 нэгж
------	---	---

	байгууллагаас гаргадаг холбогдох тайлан гарах хугацаа болоогүйгээс шалтгаалж үнэлэх боломжгүй байна. Үүнд: Эдийн засгийн бодлого	хувиар бага үзүүлэлттэй гарсан байна. Үүнд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. 1. Нүүрсний хилийн үнэ: 2024 онд нүүрсний хилийн үнэ тонн тутамд 104 ам.доллар байсантай уялдуулж, 2025 оны нүүрсний хил үнийг 105 ам.доллар байхаар төсөөлсөн. Гэвч Азийн, ялангуяа БНХАУ болон Энэтхэг улсын импортын эрэлт суларч, бүс нутгийн геополитикийн тодорхойгүй байдал нэмэгдсэн, мөн сэргээгдэх эрчим хүчинд шинжилж хандлага эрчимжсэн зэрэг шалтгаанаар дэлхийн зах зээл дэх нүүрсний нийт эрэлт буурч, улмаар үнэ уналттай байсан. Үүний улмаас 2025 оны эхний хагас жилд уул уурхайн биржийн арилжаа хумигдаж, оффтоэйж гэрээний нөхцөлтэй нүүрс экспортын дийлэнх хувийг бүрдүүлсэн нь нүүрсний хил үнийг бууруулж, 2025 оны жилийн эцсийн байдлаар тонн тутамд 64 ам.доллар болсон байна. 2. Уул уурхайн салбарын нөлөө: Уул уурхайн бүтээгдэхүүний хилийн үнэ буурч, тус салбарын өсөлт саарснаар уул уурхай дагасан бусад салбар, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны идэвхжил мөн буурсан нь эдийн засгийн өсөлт зорилтод түшиггээс доогуур гүйцэтгэлтэй гаргахад нөлөөлсөн.
2.24	Хэрэгжүүлэгч байгууллага болон хамтран хэрэгжүүлэгчийн зохион байгуулалтаас шалтгаалсан:	
	Шинжлэх ухааны парк /зорилтот түвшин-1, хүрсэн түвшин 0 буюу эрх зүйн орчин бүрдээгүй тул энэ ажил хийгдэх боломжгүй байна./	"Шинжлэх ухааны парк ..." гэснийг хасах, учир нь Инновацийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт Шинжлэх ухааны паркийг байгуулах, паркийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, үйл ажиллагаа, түүний удирдлага зохицуулалтыг 4 зүйл, 10 хэсэг, 22 заалтын хүрээнд зохицуулж байна. Энэ хүрээнд 2026 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар үндэсний хэмжээнд МУИС-ийн дэргэд Улаанбаатар шинжлэх ухаан, технологийн паркийг 2025 онд байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн.
2.24	Санхүүжилтээс шалтгаалсан:	
	Хэрэгжүүлсэн судалгаа хөгжүүлэлтийн ажлын тоо /зорилтот түвшин-1650, хүрсэн түвшин-1254, 2025 оны Улсын төсвийн тодотголоор судалгаа хөгжүүлэлтийн зардлыг 53.1 хувь хүртэл бууруулсан./	"зорилтот түвшин 1650" гэснийг "зорилтот түвшин 1310" гэж засах (УХЖТ-2025-ын хяналт-шинжилгээний үзүүлэлтийн 1.12.1.5-д заасан зорилтот түвшнээр авав.)
	Хөтөлбөрт хамрагдсан судлаачид /зорилтот түвшин-500, хүрсэн түвшин-0, 2025 оны Улсын төсвийн тодотголоор төсөв хасагдсан./	"Хөтөлбөрт хамтрагдсан судлаачид ..., 2025 оны Улсын төсвийн тодотголоор төсөв хасагдсан" гэснийг "..., 2025 оны Улсын төсвийн тодотголоор уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр батлагдсан төсөв бүхэлдээ хасагдсан" гэж засах;

		2.26-ийн хүснэгт 11-ийн "12. Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлнэ." мөрийн үр дүн гарсан шалгуур үзүүлэлт "4" гэснийг "6", үр дүнгүй шалгуур үзүүлэлт "9" гэснийг "7" болгох, уялдуулан үнэлгээний дундаж хувийг шинэчлэх. Гэхдээ үр дүнгүй шалгуур үзүүлэлт гэдгийг 2 янзаар үнэлэх нь зүйтэй байна. Учир нь үр дүнгүй "7" үзүүлэлт дотор хэрэгжсэн арга хэмжээний хувьд төсөв танагдсан, мөн зорилтот түвшнийг бүрэн хангаагүй ч тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг "үр дүнгүй шалгуур үзүүлэлт" рүү оруулж тооцох нь хэрэгжсэн ажлуудыг бодитоор үнэлэх боломжийг хязгаарлаж байна. Иймд "үр дүнгүй шалгуур үзүүлэлт" баганыг "зорилтот түвшнийг бүрэн хангаагүй ч тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн", "зорилтот түвшнийг бүрэн хангаагүй, огт арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй" гэсэн 2 багана болгон дүгнэх нь зүйтэй гэж үзэж байна.
2.66	4.1 "Шинжлэх ухаан технологи, инновац, хиймэл оюун ухааны салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ" ТЭЗ-ын үр дүнгийн "судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь" шалгуур үзүүлэлтийн биелэлт 2025 оны улсын төсвийн зардлын хуваарилалтад 115.0 сая төгрөг батлагдсан ч 2025 оны улсын төсвийн тодотголоор шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр арга хэмжээний төсөв 53.1 хувиар танагдаж төсөвлөсөн зардал хасагдсан тул эрдэм шинжилгээ, судалгааны зардал буурахад хүрч үр дүнд хүрээгүй.	2.66-ийн 4.1 дэх хэсэг, 2.68-ийн "Санхүүжилт шийдвэрлээгүй хөтөлбөрүүд" хэсгийн 4.1.1 дэх хэсэгт тухайн салбарын ТЭЗ-ийн үр дүнтэй уялдуулж хэрэгжилтийг гаргах тул 2025 оны УХЖТ-нд ЦХИХХЯ, ХЗДХЯ, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын чиг үүргийн хүрээнд байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, төсвөөр засах. Учир нь 2.66-ийн 4.1 дэх хэсэгт шинжлэх ухаан, технологийн салбарын судалгаа хөгжүүлэлт, төсөл үр дүнгээр тайлагнасан нь алдаатай байна. Иймд 2.66-ийн 4.1 дэх хэсэг, 2.68-ийн 4.1.1 дэх хэсэгт "Бүтээгдэхүүний загварын патент" гэсэн үзүүлэлтийг тус тус хасах, мөн 2.68-ын "Санхүүжилт шийдвэрлээгүй хөтөлбөрүүд" хэсгийн 4.1.1 дэх хэсгийг УХЖТ-2025-д заасны дагуу "шинэ бүтээл, зохиогчийн эрх" гэсэн 2 шалгуур үзүүлэлтээр авч үзэх, үүнтэй уялдуулан үнэлгээг засах. (2.73-ын хүснэгт 16-ын 20. 4.1.1.1-д харгалзах үнэлгээний хувийг засах).

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Эдийн засаг, хөгжлийн яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Засгийн газрын хэрхэг эрхлэх газар:

Санал 1	Аудитын тайлангийн ерөнхий дүгнэлтийг агуулгын хувьд өөрчилсөн.
Санал 2	Саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан.
Санал 3	Саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан.
Санал 4	Саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан.
Санал 5	Саналыг хүлээн авч, холбогдох арга хэмжээг дахин хянасан.
Санал 6	Саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан.

Эдийн засгийн хөгжлийн яам:

Санал 1	1.10 Саналыг хүлээн аваагүй.
Санал 2	1.7.3.3 Төслийн хэрэгжилтийн хувь гэж тодорхойлох байсан тул саналыг хүлээн авах боломжгүй.
Санал 3	2.1.2.1 Бэлэн байдлыг хангах гэдгийг хэрэгжилтийн хувиар гэж тодорхойлох тул саналыг хүлээн авах боломжгүй.
Санал 4	4.6.1.9 Суурь түвшин дээр Зорилтот түвшнийг нэмж гаргаагүй байгаа нь хяналт-шинжилгээ, хийх журамд заасан аргачлалаар үнэлэх боломжгүй байдал үүсгэж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Санал 5	3.1.4 Суурь түвшин дээр Зорилтот түвшнийг нэмж гаргаагүй байгаа нь хяналт-шинжилгээ, хийх журамд заасан аргачлалаар үнэлэх боломжгүй байдал үүсгэж байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Санал 6	3.1.2.1 Суурь түвшнийг 2023 оны байдлаар 458 байхыг 250 гэж буруу тодорхойлсон.
Санал 7	1.13 Аудитын тайланд энэ талаар тодорхой тусгасан тул саналыг хүлээн авах боломжгүй байна.
Санал 8	1.16 Саналыг хүлээн авч хавсралтаар оруулав.
Санал 9	2.6 Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн аваагүй.
Санал 10	2.15. Аудитын нотлох баримтаар нотлогдож байгаа болно.
Санал 11	2.24 “Салбар дундын, салбар дамнасан судалгаа хөгжүүлэлтэд түшиглэсэн хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засаг, засаглалын цогц нэгдэл бүхий шинжлэх ухаан, технологийн паркийн төслийг хэрэгжүүлэх” арга хэмжээний хүрээнд хамааралгүй ажлыг тайлагнасан байна.
Санал 12	2.24 Хөтөлбөрийн үр дүнгийн 1.12.1 зорилтот түвшин 1650-г тайланд тусгасан. Гэтэл ирүүлсэн саналд 1.12.1.5 ТАХ-ний үр дүнгийн зорилтот түвшнийг бичсэн байна.
Санал 13	2.24 Нотлох баримтаар дэмжигдсэн тул саналыг хүлээн авах боломжгүй
Санал 14	2.66 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хөтөлбөр, ТАХ нь тусдаа шалгуур үзүүлэлттэй, түүний дагуу тус бүр аудитлагдсан үнэлгээ гарсан тул ТАХ-ний дундаж үнэлгээгээр хөтөлбөрийн үнэлгээг гаргах боломжгүй байна.